



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



БОАЖА-НЫ
ОЗОНЫ ҮНДЭСНИЙ АЛБА



НҮБ-ЫН БАЙГАЛЬ
ОРЧНЫ ХӨТӨЛБӨР



**ХӨРГӨЛТ, АГААРЖУУЛАЛТЫН ЗАСВАР
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНИКИЙН АЖИЛТНУУДЫГ
ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ ТОГТОЛЦОО НЭВТРҮҮЛЖ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААРХ ҮНДЭСНИЙ ОРОЛЦОГЧ
ТАЛУУДЫН ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТЫН
ЭМХЭТГЭЛ**

УЛААНБААТАР ХОТ
2020 ОН



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



БОАЖА-НЫ
ОЗОНЫ ҮНДЭСНИЙ АЛБА



НҮБ-ЫН БАЙГАЛЬ
ОРЧНЫ ХӨТӨЛБӨР

**ХӨРГӨЛТ, АГААРЖУУЛАЛТЫН ЗАСВАР
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНИКИЙН АЖИЛТНУУДЫГ
ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ ТОГТОЛЦОО НЭВТРҮҮЛЖ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААРХ ҮНДЭСНИЙ ОРОЛЦОГЧ
ТАЛУУДЫН ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТЫН ЭМХЭТГЭЛ**

**COMPILATION OF NATIONAL
STAKEHOLDERS CONSULTATION ON
CERTIFICATION SYSTEM FOR REFRIGERATION
AND AIR CONDITIONING SERVICING SECTOR
TECHNICIANS**

УЛААНБААТАР
2018

АГУУЛГА

1.	ТАНИЛЦУУЛГА.....	3
2.	ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТЫН ХӨТӨЛБӨР.....	4
3.	ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТЫН ЗӨВЛӨМЖ.....	8
4.	ХЭЛЭЛЦҮҮЛСЭН ИЛТГЭЛҮҮД.....	13
5.	ЗАМЫН ЗУРАГ.....	109
6.	ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, САНАЛ.....	110
7.	ХАВСРАЛТ	114
7.1.	Хавсралт I:	

Энэхүү гарын авлагыг “Монгол улсад Гидрохлортфторт нүүрстөрөгч бодисыг үе шаттай бууруулах менежментийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Олон талт сан”-гаас санхүүжүүлэн хэвлүүлэв.

Боловсруулсан: БОАЖЯ-ны Озоны үндэсний албаны
Гидрохлортфторт нүүрстөрөгч бодисыг үе шаттай
бууруулах менежментийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх
Төслийн нэгж

Хянасан: Д.Дуламсүрэн

ХӨРГӨЛТ, АГААРЖУУЛАЛТЫН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНИКИЙН АЖИЛТНУУДЫГ ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ ТОГТОЛЦОО НЭВТРҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААРХ ҮНДЭСНИЙ ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТЫН ТАНИЛЦУУЛГА

2018 оны 06 дугаар сарын 08
Улаанбаатар зочид буудал, “Хөх асар” танхим

Ерөнхий мэдээлэл

- Озон задалдаг бодисын тухай Монреалийн протокол нь озоны давхаргыг хамгаалах асуудлыг хуульчилсан, Монгол Улс болон НҮБ-ын гишүүн орнууд нэгдэн орсон олон улсын гэрээ юм. Уг протокол нь озон задалдаг бодисын 98%-ийг (голдуу хлортфторт нүүрстөрөгч ХФН/СFC) хэрэглээнээс халахад тусалсан ба эдгээр бодисуудыг юуны өмнө хөргөлт, агааржуулалтын салбарт хөргөлтийн хий хэлбэрээр мөн хөөсөнцрийн үйлдвэрлэлд ашиглаж байв.
- Одоогийн байдлаар Монгол Улс болон бусад улс орнууд озон задалдаг, дэлхийн дулааралд үлэмж нөлөөтэй хоёрдугаар үеийн хөргөх бодис ГХФН/НСFC (гидрохлортфторт нүүрстөрөгч)-ийг “ГХФН/НСFC төрлийн бодисыг үе шаттай бууруулах менежментийн хөтөлбөр (HPMP)”-ийг хэрэгжүүлэх замаар үе шаттай бууруулж байна. Монгол Улс HPMP хөтөлбөрийн дагуу ГХФН/НСFC төрлийн бодисын хэрэглээг 2020 он гэхэд урьдчилж тогтоосон суурь түвшинээс 35% бууруулах, 2030 он гэхэд хэрэглээнээс бүрмөсөн халах зорилттой ба ингэхдээ 2040 он хүртэл үйлчилгээнд байгаа тоног төхөөрөмжийн ажиллагааг хангах зориулалтаар суурь түвшний 2.5%-тай тэнцэх хэмжээний бодис ашиглахыг зөвшөөрнө. Манай орны хувьд ГХФН/НСFC төрлийн бодисын хэрэглээний суурь түвшин 25 тонн (1.4 ОЗЧтонн) байсан ба 2016 онд 0.45 ОЗЧтонн бодис хэрэглэсэн хэмээн тайлагнасан байна. HPMP хөтөлбөр батлагдсан хуваарийнхаа дагуу амжилттай хэрэгжиж байна.
- Улс орнууд озон задалдаг бодисын хэрэглээгээ бууруулах зорилтоо биелүүлэхийн хэрээр түүнийг “орлуулах хөргөх бодис” буюу нүүрсустөрөгч (НУ/НС), аммиак (NH₃), нүүрстөрөгчийн давхар исэл (нүүрсхүчлийн хий CO₂), ханаагүй гидрофторт нүүрстөрөгч (ГФН/НFC) болох гидрофторт олефин (ГФО/НFO) төрлийн бодисууд, ГФО/НFO агуулсан хольцын хэрэглээ ялангуяа хөгжиж буй орнуудад их хэмжээгээр нэмэгдэнэ гэж таамаглаж байна. Хэдийгээр байгаль орчинд үзүүлэх нөлөө нь ХФН/СFC, ГХФН/НСFC төрлийн бодисуудтай харьцангуй маш бага боловч зарим орлуулах бодис хортой, шатамхай, их даралттай зэрэг шинж чанар агуулдаг. Иймээс хөргөлт, агааржуулалтын салбар эдгээр орлуулах хөргөх бодисын техникийн болон аюулгүй байдлын асуудалд дасан зохицох шаардлага тулгарч байна.
- Ялангуяа эдгээр хөргөх бодисыг агуулсан хөргөлт, агааржуулалт, дулааны насосын тоног төхөөрөмжийг суурилуулах, засвар, үйлчилгээ

хийх, ашиглалтаас гаргахад ажилтнуудын чадамж маш чухал юм. Засвар үйлчилгээний техникийн ажилтнуудыг гэрчилгээжүүлэх нь хөргөх бодистой харьцдаг ажилтнуудын чадварыг шалгах, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангах, тухайн тоног төхөөрөмжийг ашиглагч, хэрэглэгчдийг аливаа эрсдэлд оруулахгүй байх үр дүнтэй арга юм.

Уулзалтын ерөнхий зорилт, хүлээж буй үр дүн:

- Үндэсний оролцогч талууд болон уулзалтын бүх оролцогчид хөргөлт, агааржуулалтын засвар үйлчилгээний техникийн ажилтнуудын чадамжийг баталгаажуулах гэрчилгээжүүлэлтийн тогтолцооны хэрэгцээ, шаардлагын талаар тодорхой ойлголт авч, хоорондоо хэлэлцсэний үндсэн дээр уг ажлыг хэрэгжүүлэх дараа дараагийн алхмуудыг тодорхойлж, хийх ажил, хүлээх үүрэг, хариуцлагаа хуваарилна.

ҮНДЭСНИЙ ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТЫН ХӨТӨЛБӨР

2018 оны 06 сарын 08-ны өдөр			
Хугацаа	Үйл ажиллагаа	Байгууллага	Хүлээж буй үр дүн
09:00-09:30	Оролцогчдыг бүртгэх	Озоны үндэсний алба (ОУА)	
I хэсэг	Нээлтийн ажиллагаа болон оролцогчдыг танилцуулах		
09:30-10:30	<p>ОУА-ны захирал проф. Ц.Адъяасүрэн</p> <p>БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга Г.Нямдаваа</p> <p>ХНХЯ-ны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Мэргэжлийн боловсрол сургалтын хэлтсийн дарга А.Халиунаа</p> <p>НҮБ-ын БОХ-ийн Ази, Номхон далайн бүс хариуцсан газрын ажилтан хатагтай Ляззат Раббиоси</p> <p>Япон улсын Байгаль орчны яамны зөвлөх ноён Тохи Ниро</p> <p>Оролцогчдыг танилцуулах</p>	<p>ОУА БОАЖЯ</p> <p>ХНХЯ</p> <p>НҮБ-ын БОХ-ийн Ази, Номхон далайн бүс хариуцсан газар</p> <p>Японы Байгаль орчны яам</p>	Уулзалтын зорилт, түүнд хүрэхийн тулд оролцогч талууд ямар үүрэг гүйцэтгэх талаар тодорхой ойлголттой болох
10:30-11:00	Цайны завсарлага, хэвлэл мэдээлэлд ярилцлага өгөх, зураг авахуулах		
II хэсэг	Монгол Улсад Монреалийн протоколыг хэрхэн хэрэгжүүлж байгаа болон Хөргөлт, агааржуулалтын засвар үйлчилгээний салбарт яагаад гэрчилгээжүүлэх тогтолцоо нэвтрүүлэх хэрэгтэй вэ?		

11:00-11:20	<p>МОНРЕАЛИЙН ПРОТОКОЛ ЯАГААД ЧУХАЛ БӨГӨӨД МОНГОЛ УЛСАД ХЭРХЭН ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА ВЭ?</p> <ul style="list-style-type: none"> - Озоны давхаргын хамгаалалт, уур амьсгалын өөрчлөлт - Монреалийн протокол, ОЗБ-ыг үе шаттай бууруулах хуваарь, Кигалийн нэмэлт өөрчлөлт - Озоны цоорхойн байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө - Монгол Улсад HCFC бодисыг үе шаттай бууруулах менежментийн төлөвлөгөө (HPMP)-ний хэрэгжилт: HPMP хөтөлбөрийн зорилго, түүнийг хэрэгжүүлэхэд олон талын оролцоо, үүрэг хариуцлага (МХХАХ, Барилга, хот байгуулалтын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгаалалтын яам, Мэргэжлийн хяналтын байгууллага, бусад агентлагууд) 	ОУА-ны захирал Проф. Ц.Адъяасүрэн	Монреалийн протокол ба уг протоколд нэгдэн орсон Тал улс орны хүлээсэн үүргийг Монгол Улс хэрхэн гүйцэтгэж байгаа талаар тодорхой ойлголттой болох
11:20-11:50	<p>ОЛОН УЛСЫН ХӨРГӨЛТ, АГААРЖУУЛАЛТ, ХӨӨСӨНЦӨРИЙН САЛБАРТ АШИГЛАЖ БУЙ ОРЛУУЛАХ БОДИСЫН ӨНӨӨГИЙН ЧИГ ХАНДЛАГА</p> <ul style="list-style-type: none"> - Орлуулах хөргөх бодисын технологийн өнөөгийн чиг хандлага - HCFC, HFC төрлийн бодисын орлуулах бодис - Озон задалдаггүй, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар багатай, шатамхай хөргөх бодис - Үйлдвэрлэгч орнууд болон Европын Холбооны орнуудын хөргөлт, агааржуулалтын салбарт ашиглаж буй хөргөх бодисын өнөөгийн чиг хандлага 	НҮБ-ын БОХ, Ази, Номхон далайн бүс хариуцсан ажилтан Ляаззат Раббиоси	Монреалийн протоколын хэрэгжилтийн дэлхий дахины нөхцөл байдал, Хөргөлт, агааржуулалтын засвар үйлчилгээний салбарыг чадварлаг байх шаардлагатай болгосон зах зээлийн чиг хандлага
11:50-12:35	<p>ХӨРГӨЛТ, АГААРЖУУЛАЛТЫН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНИКИЙН АЖИЛТНУУДЫН ЧАДАМЖ ХЭР ЧУХАЛ ВЭ?</p> <ul style="list-style-type: none"> - Техникийн ажилтнуудын чадамжийг баталгаажуулах, гэрчилгээжүүлэх нь яагаад чухал вэ? <p><u>Хөргөлт, агааржуулалтын засвар үйлчилгээний салбарт хууль ёсны гэрчилгээжүүлэлтийн тогтолцоог нэвтрүүлэх нь</u></p> <ul style="list-style-type: none"> - Озоны үе давхаргыг хамгаалахад чиглэсэн үндэсний хууль тогтоомжууд: Озон задалдаг бодис болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийг импортлох, худалдах, ашиглах зөвшөөрлийн тогтолцоо, хууль эрх зүйн үндсийг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага - Хөргөлт, агааржуулалтын засвар, үйлчилгээний техникийн ажилтнуудын гэрчилгээжүүлэлтийн өнөөгийн нөхцөл байдал - Мэргэжлийн болон техникийн боловсрол, мэргэжлийн сургалтын мэргэшлийн түвшинд хөргөлт, агааржуулалтын засвар, үйлчилгээний техникийн ажилтнуудыг гэрчилгээжүүлж, баталгаажуулах асуудлыг тусгах - Гэрчилгээжүүлэлт, баталгаажуулах асуудалд холбогдох төрийн захиргааны төв байгууллага, БОАЖЯ-ны дэмжлэг, бусад байгууллагуудын хамтын ажиллагаа - Гэрчилгээжүүлэлтийг хууль ёсны болгоход оролцогч талуудын хүлээх үүргийг тодорхойлох, замын зургийн төсөл 	<p>ОУА-ны ахлах мэргэжилтэн Д.Дуламсүрэн</p> <p>БОАЖЯ-ны хуулийн хэлтсийн мэргэжилтэн Д.Сайнбаяр</p> <p>Байгаль орчны аудитор Ц.Мөнхбат</p>	Техникийн ажилтны чадамж яагаад чухал мөн гэрчилгээжүүлэлтийн тогтолцоогоор дамжуулж түүнийг баталгаажуулах боломжийн талаар тодорхой ойлголттой болох
12:35-13:20	<p>ХӨРГӨЛТ, АГААРЖУУЛАЛТЫН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНИКИЙН АЖИЛТНУУДЫГ ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ, БАТАЛГААЖУУЛАХ ТОГТОЛЦОО</p>	НҮБ-ын БОХ, Ази, Номхон далайн бүс хариуцсан	

12:35-13:20	<p>ХӨРГӨЛТ, АГААРЖУУЛАЛТЫН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНИКИЙН АЖИЛТНУУДЫГ ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ, БАТАЛГААЖУУЛАХ ТОГТОЛЦОО НЭВТРҮҮЛСЭН ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА</p> <ul style="list-style-type: none"> - Хөргөлт, агааржуулалтын засвар үйлчилгээний техникийн ажилтнуудыг гэрчилгээжүүлэх тогтолцоо - Олон улсын туршлага-Европын Холбоо болон Ази, Номхон далайн бүсийн улс орнуудын жишээн дээр - НҮБ-ын БОХ -өөс санаачилсан “Хөргөлт, агааржуулалтын жолооны үнэмлэх”- Refrigerant Driving licenses <p>ФИЛИППИН УЛСЫН ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТИЙН ТОГТОЛЦОО НЭВТРҮҮЛСЭН ТУРШЛАГА</p> <ul style="list-style-type: none"> - Филиппин улсын үнэлгээ ба гэрчилгээжүүлэлтийн тогтолцооны бүтэц 	<p>НҮБ-ын БОХ, Ази, Номхон далайн бүс хариуцсан ажилтан Ляаззат Раббиоси</p> <p>НҮБ-ын БОХ-ийн сургагч багш, мэргэжилтэн Мануэл Азусена</p>	
13:20-14:20	Үдийн зоог		
III хэсэг	Бид хаана явж байгаа вэ?: Монгол Улсын Хөргөлт, агааржуулалтын салбар, Мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцооны одоогийн нөхцөл байдал болон бусад мэргэжлийг гэрчилгээжүүлсэн туршлага		
14:20-14:40	<p>ТЕХНИКИЙН БОЛОН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН АГУУЛГА, СТАНДАРТ</p> <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын боловсролын тогтолцоо - Мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцооны шинэчлэл - Мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоо - Мэргэжлийн боловсролын мэргэшлийн түвшин - Хууль эрх зүйн шинэчлэл - Мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга - Ажил мэргэжлийн лавлах - Ажил мэргэжлийн лавлахын бүтэц - Мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт - Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр 	<p>Техникийн болон Мэргэжилийн боловсрол, сургалтын агуулга, арга зүй хариуцсан мэргэжилтэн Д.Эрдэнэбат</p>	<p>Монгол Улсын мэргэжлийн болон техникийн боловсролын тогтолцооны талаар тодорхой ойлголттой болох: Хөргөлт, агааржуулалтын засвар, үйлчилгээний ажилтнуудын гэрчилгээжүүлэлтийн тогтолцоо бий болгохын тулд одоогоор хийгдсэн болон цаашид хийх шаардлагатай ажлууд</p>
14:40-15:00	<p>САНТЕХНИК, ХАЛААЛТ, АГААРЖУУЛАЛТЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАРЧИН, ТЕХНИКЧИЙН ЧАДАМЖИД СУУРИЛСАН ХӨТӨЛБӨРИЙН ШИНЧЛЭЛИЙН ТАЛААРХ ТУРШЛАГА</p> <ul style="list-style-type: none"> - “Ашигт малтмалын салбар дахь түншлэлд суурилсан мэргэжлийн боловсрол, сургалт” /ТСМБМ/ - Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулсан өмнөх туршлага - Сантехник, халаалт, агааржуулалтын төхөөрөмжийн Техникийн ажилтаны чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр 	<p>ГОУХАН (GIZ)-ийн “Ашигт малтмалын салбар дахь түншлэлд суурилсан мэргэжлийн боловсрол, сургалт” төслийн мэргэжилтэн Б.Болор</p>	<p>Өөр бусад техникийн мэргэжлийг гэрчилгээжүүлэлттэй болгох ажлын явцаас авсан сургамж</p>
15:00-15:20	<p>ХӨРГӨЛТ, АГААРЖУУЛАЛТЫН САЛБАРЫН АЖИЛ ОЛГОГЧ НАРЫН ХУВЬД ТУС САЛБАРЫН ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНИКИЙН АЖИЛТНУУДЫГ ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ, БАТАЛГААЖУУЛАХ ТОГТОЛЦОО НЭВТРҮҮЛЭХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА</p> <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын хөргөлт, агааржуулалтын угсралт, засвар үйлчилгээний салбарын чиг хандлага - Хөргөлт, агааржуулалтын салбарын техникийн ажилтнуудын өнөөгийн байдал - Гэрчилгээжүүлэх, баталгаажуулахын давуу тал - Мэргэшсэн байх хууль ёсны хэрэгцээ шаардлага, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн давуу тал 	<p>МХХАХ-ны Ерөнхийлөгч Ц.Өсөхжаргал</p> <p>“Мастер чадамж” сургалт, судалгааны төвийн тэргүүн, ШУТИС-ын багш, доктор, (PhD)</p>	<p>Монголын хөргөлт, агааржуулалтын салбарын одоогийн нөхцөл байдал ба гэрчилгээжүүлэх тогтолцоо нэвтрүүлснээр уг салбарт ямар үр өгөөж өгөх талаар</p>

	<ul style="list-style-type: none"> - Олон улсад өрсөлдөх чадвар, компани нэр хүндэд нөлөөлөх нь - Монголын хөргөлт, халаалт, агааржуулалтын холбооны дэргэдэх "Мастер чадамж" сургалт судалгааны төвийн танилцуулга, зорилго - Зохион байгуулсан сургалтууд, сургалтын зорилго, туршлага, сургамж - Цаашдын зорилго, хэрэгжүүлэх үйл ажиллагаа 	Ш.Энх-Амгалан	ойлголттой болох
15:20-15:40	Цайны завсарлага		
IV хэсэг	Урагшлах арга зам: Юуг яаж хийх хэрэгтэй вэ?		
15:40-16:00	<p>ТЕХНИКИЙН БОЛОН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТОГТОЛЦОО, ОЛОН УЛСЫН ЖИШИГТ НИЙЦСЭН ҮНДЭСНИЙ МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ НЬ</p> <ul style="list-style-type: none"> - Мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээний төвийн бүтэц, үйл ажиллагааны чиглэл - Оролцогч талуудын хамтын ажиллагаа - Үнэлгээний журам - Мэргэжлийн ур чадвар, мэргэжлийн түвшинг үнэлэх, гэрчилгээжүүлэх, баталгаажуулах - Гэрчилгээжүүлэлтийн шинэчлэл - Үнэлгээ, баталгаажуулалтын шинэчлэл 	Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын яамны Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн дарга Ц.Батдорж, Арга зүйч С.Лувсанвандан	Гэрчилгээжүүлэх тогтолцоо нэвтрүүлэхэд шаардагдах хууль эрх зүйн алхмуудын талаар тодорхой ойлголттой болох
15:50-16:10	<p>ХӨРГӨЛТ, АГААРЖУУЛАЛТЫН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНИКИЙН АЖИЛТНЫ МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ТӨСӨЛ</p> <ul style="list-style-type: none"> - Хөргөлт, агааржуулалтын тоног төхөөрөмжийн засварчин мэргэжлийн ажил мэргэжлийн лавлах, техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын стандартын төсөл - Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн санал 	Технолгийн дээд сургуулийн багш П.Алтанцэцэг	
16:20-17:20	<p>ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, АСУУЛТ ХАРИУЛТ (WORKING GROUP)</p> <ul style="list-style-type: none"> - Хөргөлтийн тоног төхөөрөмжийн засварчин (CF 8211-23), Халаалт, агааржуулалт, хөргөлтийн тоног төхөөрөмжийн засварчин (CF 7126-26), Агааржуулах болон хөргүүрийн тоног төхөөрөмжийн засварчин (IM 7233-36), Агааржуулалт, агаар сэлгэлтийн тоног төхөөрөмжийн механик (IM 7233-19), Агааржуулалт, агаар сэлгэлтийн системийн угсралт, ашиглалтын техникч (CF3115-51) зэрэг мэргэжлийн гэрчилгээжүүлэлт, баталгаажуулалтыг техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын түвшинд хэрхэн авч үзэх вэ? - Гэрчилгээжүүлэлтийг хэрхэн хууль ёсны болгох вэ? - Гэрчилгээжүүлэлтэд оролцогч талуудын оролцоо, үүрэг хариуцлагыг хэрхэн тодорхойлж, хамтран ажиллах вэ? 	НҮБ-ын БОХ ОУА МХХАХ ХНХЯ-ны МБГ	
17:20-18:20	<p>ДҮГНЭЛТ, ЦААШДИЙН АРГА ЗАМЫГ ХЭЛЭЛЦЭХ</p> <ul style="list-style-type: none"> - Эрх зүйн орчныг боловсронгуй болгох үндэслэлийг тодорхойлох - Хөргөлт, агааржуулалтын техникийн ажилтнуудын чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах замын зургийн төсөлд оролцогч талуудын саналыг тусгах - Ажил мэргэжлийн лавлах, мэргэжлийн боловсрол сургалтын стандарт, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах тухай зөвлөмж гаргах 	НҮБ-ын БОХ ОУА БОАЖЯ МХХАХ ХНХЯ-ны МБГ	

ХӨРГӨЛТ, АГААРЖУУЛАЛТЫН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНИКИЙН АЖИЛТНУУДЫГ ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ ТОГТОЛЦОО НЭВТРҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААРХ ҮНДЭСНИЙ ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ”-ЫН ЗӨВЛӨМЖ

Улаанбаатар хот

2018 оны 6 дугаар 08

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн Ozon Action хөтөлбөр, Ази, Номхон далайн бүсийн салбар, БОАЖЯ-ны Озоны үндэсний алба, Монголын хөргөлт, халаалт, агааржуулалтын холбоо хамтран, Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Мэргэжлийн боловсрол сургалтын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Мэргэжлийн боловсролын бодлогын хэрэгжилтийн газар, Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн дэмжлэгтэйгээр “Хөргөлт, агааржуулалтын засвар үйлчилгээний техникийн ажилтнуудыг гэрчилгээжүүлэх тогтолцоо нэвтрүүлж хэрэгжүүлэх талаарх үндэсний оролцогч талуудын зөвлөлдөх уулзалт”-ыг 2018 оны 06 дугаар сарын 8-ны өдөр Улаанбаатар зочид буудлын “Хөх асар” танхимд амжилттай зохион байгууллаа.

Энэхүү зөвлөлдөх уулзалтаар Дэлхийн улс орнууд ялангуяа өндөр хөгжилтэй болон үйлдвэрлэгч орнууд озон задалдаг бодис (ОЗБ)-ын хэрэглээгээ бууруулах зорилтоо биелүүлэхийн тулд ОЗБ-ыг орлуулах бодисууд болох аммиак(NH_3), нүүрстөрөгчийн давхар исэл (CO_2), ханаагүй гидрофторт нүүрстөрөгч (HFC) төрлийн хольц бодисуудыг өргөн хэрэглэж байгааг онцлон тэмдэглэв.

Дээрх бодисууд нь өндөр даралттай, шатамхай шинж чанартай тул хөргөлт, агааржуулалт, дулааны насосын тоног төхөөрөмжийг суурилуулах, засвар үйлчилгээ хийхэд засвар үйлчилгээний техникийн ажилтнуудын мэдлэг, ур чадвар маш чухал байх тул тэдний чадамжийг үнэлэх чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, чадамжийн гэрчилгээ олгох тухай асуудлыг олон салбарын төлөөллийн хамтын оролцоотойгоор хэрхэн шийдвэрлэх талаар хэлэлцэв.

Зөвлөлдөх уулзалтанд хэлэлцүүлсэн илтгэл, хэлэлцүүлгийн үр дүн болон оролцогчдоос гаргасан саналыг үндэслэн зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг **ЗӨВЛӨМЖ** болгож байна. Үүнд:

Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын яаманд:

- БСШУ-ны сайдын 2016 оны А/150 дугаар тушаалаар батлагдсан холбогдох салбарын ажил мэргэжлийн нэр томъёо, хийдэл, давхардлыг дахин хянаж үзэх, шинэчлэн найруулах, бусад салбаруудтай уялдуулах, шаардлагатай шинэ ажил мэргэжилийг шинээр нэмж тусгах тухай асуудлыг ажил олгогч нар болон мэргэжлийн холбоо бусад холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэх;
- БСШУ-ын сайдын 2016 оны А/150 дугаар тушаалаар баталсан Мэргэжлийн чиглэл, индексийн барилгын салбарт: Хөргөлт, агааржуулалт, халаалтын тоног төхөөрөмжийн засварчин, техникч гэсэн 2 ажил мэргэжил, аж үйлдвэрийн салбарт Хөргөлтийн тоног төхөөрөмжийн засварчин, техникч гэсэн 2 ажил мэргэжлийг, тээврийн салбарт автомашины агааржуулалтын системийн засварчин ажил мэргэжлийг шинээр нэмж тусгах;
- Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаар бэлтгэх мэргэжлийн чиглэл, индекст орсон хөргөлт, агааржуулалтын тоног төхөөрөмжийн засварч техникч мэргэжлийн ажил мэргэжлийн лавлах боловсруулах, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах ажлыг холбогдох яам, агентлаг, мэргэжлийн холбоодтой хамтран боловсруулах ажлыг эхлүүлэх, арга зүйгээр хангах;
- Мэргэжлийн боловсролын үндэсний зөвлөлд хөргөлт, агааржуулалтын чиглэлээр салбар зөвлөлтэй болох, тус зөвлөл нь дээрх салбарын ажил олгогчдоос мэргэшлийн тодорхойлтуудыг түвшин тус бүрээр гаргуулдаг байх нөхцөлийг, нөгөө талаас тус салбар зөвлөлд ажил, мэргэжлийн тодорхойлолтоо гаргаж өгөөгүй ажил олгогч байгууллагуудад хариуцлага тооцдог байх асуудлыг холбогдох хууль, тогтоомжид тусгах асуудлыг мэргэжлийн холбоо болон ажил олгогч тал, Мэргэжлийн боловсролын үндэсний зөвлөлтэй хамтран шийдвэрлэх;

Байгаль орчин, аялал жуучлалын яаманд:

- БОАЖЯ-наас хөргөлт, агааржуулалтын техник, тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийх үйлчилгээний ажилтнуудыг сургах, гэрчилгээжүүлэх, энэ чиглэлийн ажил мэргэжлийн лавлах, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах талаар Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын газартай хамтран ажиллах;
- Монгол Улсын Агаарын тухай хуулийн 25.2 дахь хэсэгт заасан ОЗБ болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийг импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөл олгох журам, 25.4 дэх хэсэгт заасан ОЗБ болон бусад орлуулах бодисыг юүлэх, дахин боловсруулах, тоног төхөөрөмжийг дахин цэнэглэх үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагын эрх олгох журмыг тус тус шинээр болон шинэчлэн батлуулах асуудлыг Озоны үндэсний алба болон мэргэжлийн холбоо, ажил олгогч нартай хамтран хариуцан шийдвэрлэх;

- Хөргөлт, агааржуулалтын салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх асуудал нь сургалтын байгууллагаас гадна хөргөлт, халаалт, агааржуулалтын мэргэжлийн холбоо, ажил олгогчдын хүлээх үүрэг, хариуцлагын асуудал гэдэг ойлголтыг өгч, төлөвшүүлэхийг салбар хариуцсан яамнаас чиглүүлэх;

Барилгын политехник коллеж, Техник, Технологийн политехник коллеж, Хүнс технологийн политехник коллежид:

- Ажил мэргэжлийн лавлах, стандарт, хөтөлбөр боловсруулах, шалгалтын сан/тест болон ур чадварын даалгаварын сан боловсруулах багт Мэргэжлийн сургалтын байгууллага /Барилгын политехник коллеж, Техник, Технологийн политехник коллеж гэх мэт/, Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв, Мэргэжлийн холбоод /Монголын хөргөлт, халаалт агааржуулалтын холбоо/, ажил олгогч нарыг оролцуулах;
- Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн даргын тушаалаар томилдог үнэлгээний болон хөндлөнгийн баталгаажуулалтын багт Мэргэжлийн холбоод /МХХАХолбоо/, ажил олгогч, сургалтын байгууллага /МСҮТ,ПК/, МБС үнэлгээний төвийн төлөөллийг тус тус оролцуулах;
- Баталгаажуулалтын багт ажил олгогч /тухайн үнэлгээг зохион байгуулах мэргэжлийн ажил олгогч/, мэргэжлийн холбоод/тухайн үнэлгээ зохион байгуулах мэргэжлийн шинжээч/-ыг оролцуулах;
- Мэргэжлийн боловсрол, сургалтын агуулгыг боловсруулах явцад ажил олгогчдын оролцоог хангах:
 - Ажил мэргэжлийн лавлах боловсруулах–100%
 - Ерөнхий шаардлага –60%-70%-иас багагүй
 - Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр–30%-40%-иас багагүй байх зохицуулалтыг тус тус хийх.

Монголын хөргөлт, халаалт, агааржуулалтын холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоонд:

- Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн Үнэлгээний ажилтан бэлтгэх сургалтанд нарийн мэргэжлийн чадварлаг инженер, техникийн ажилтнуудыг хамруулж, тухайн мэргэшлийн үнэлгээний ажилтанг бэлтгэхэд хамтран ажиллах;
- Мэргэжлийн холбоод нь сургалтын байгууллагын төгсөгчдийн шалгалтанд үнэлгээ хийх үнэлгээний болон хөндлөнгийн баталгаажуулалтын багт орж ажиллах;

Дээрх зөвлөмжийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллага бүр үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхийг “Хөргөлт, агааржуулалтын засвар үйлчилгээний техникийн ажилтнуудыг гэрчилгээжүүлэх тогтолцоо нэвтрүүлж хэрэгжүүлэх талаарх үндэсний оролцогч талуудын зөвлөлдөх уулзалт” сэдэвт зөвлөлгөөнд оролцогчдоос уриаллаа.

ХЭЛЭЛЦҮҮЛСЭН ИЛТГЭЛҮҮД



БАЙГАЛЬ ОРЧИН
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



ОЗОНЫ ДАВХАРГЫН ЦООРХОЙ, ТҮҮНИЙГ ХАМГААЛАХЫН АЧ ХОЛБОГДОЛ, ОЛОН УЛСЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

*“Хөргөлтийн болон агааржуулалтын засвар үйлчилгээний техникийн ажилтнуудыг
гэрчилгээжүүлэх систем нэвтрүүлэх талаарх үндэсний оролцогч талуудын зөвлөлдөх уулзалт”
2018 оны 6 дугаар сарын 8*

Проф. Ц.Адьяасүрэн
Озоны үндэсний албаны захирал

АГУУЛГА

- Зөвлөлдөх уулзалтын зорилго
- Озоны давхарга ба ХЯТ
- Озоны давхаргын “цоорхой”
- Байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө
- Монреалийн протокол: ОЗБ-ыг үе шаттай бууруулах хуваарь
- Хүлэмжийн хий, дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт
- Монреалийн протоколын Кигалийн нэмэлт өөрчлөлт: ДДНЧ өндөртэй хүлэмжийн хийнүүдийг үе шаттай бууруулах хуваарь
- Орлуулах технологи: Шатамхай, хортой, өндөр даралттай хөргөх бодисууд (Alternative refrigerants)
- Хөргөлт, агааржуулалтын салбарт ОУ-ын баримтлах зарчим, ирээдүйн чиг хандлага, анхаарах асуудлууд

Зөвлөлдөх уулзалт ба тавьсан зорилго

Хөргөх бодис агуулсан хөргөлт, агааржуулалт, дулааны насос суурилуулах зэрэг засвар, үйлчилгээний ажилтануудын чадамжийг дээшлүүлэх зайлашгүй шаардлага, үр өгөөж нь:

- Озон задлах бодис болон уур амьсгалын өөрчлөлтөнд нөлөөтэй химийн бодисыг агаарт алдагдалгүйгээр засвар үйлчилгээ хийж чаддаг болсоноор агаар мандлыг хамгаалах
- Тухайн компанийн бизнесийн нэр хүнд дээшлэх
- Тухайн компанийн эдийн засгийн алдагдлыг багасгах
- Засвар үйлчилгээний ажлыг заавал мэргэжсэн, гэрчилгээтэй засварын ажилтан гүйцэтгэдэг журамд шилжих

Хөргөх бодис агуулсан хөргөлт, агааржуулалт, дулааны насос суурилуулах зэрэг засвар, үйлчилгээний ажил нь яагаад озоны давхарга, дэлхийн дулааралтай холбогдох нь

- Хөргөлт, агааржуулалт, дулааны насосанд хэрэглэдэг хөргөх бодис нь агаар мандлын дээд давхаргад байгаа озоны давхаргыг хомсдуулах болон дэлхийн дулаарлыг үүсгэж байгаа хүлэмжийн хийн нэгэн төрөлийн химийн бодис юм
- Иймд тэдгээр бодисыг агаарт алдахгүйгээр цэнэглэх, засвар үйлчилгээ хийх зайлшгүй чухал шаардлага хүн төрлөхтөний өмнө тулгарч байгаа болно.
- Эдгээрийн учир шалтгааныг авч үзье

Озоны давхарга

Озон (O_3) нь хүчилтөрөгчийн 3 атомаас тогтдог молекул юм.

Дэлхийн агаар мандалд маш бага хэмжээтэй оршдог энэхүү хийний 90 орчим хувь нь дэлхийн гадаргаас дээш:

Давхраат мандалд ~10-50 км өндөрт байх “озоны давхарга” нь Нарнаас ирж буй хэт ягаан туяа (UV)-г шүүж байдаг “сайн озон” юм.



Нарны гэрлийн долгионы ангилал





- Урт долгионт гэрэл (700 урт) - Нил улаан туяа
- Үзэгдэх гэрэл (400-700нм) – Өдрийн цагаан гэрэл
- Богино долгионт гэрэл (200-400нм)–Хэт ягаан туяа


ХЯТ-ны ангилал

1. UVA туяа (400-320 нм) – Хэт ягаан туяанаас хамгийн сул хүчтэй нь боловч арьсны эсүүдийг хөгшрүүлж тэдний ДНК-г гэмтээдэг.
2. UVB (320-290 нм) – өмнөх UVA туяанаас арай хүчтэй туяа ба арьсны эсийн ДНК-г шууд гэмтээж, арьсны хорт хавдар, нүдэнд цагаа унах өвчнүүдийг үүсгэнэ.
3. UVC (290-200 нм) – хамгийн хүчтэй туяа бөгөөд азаар энэ туяа озоны давхаргад шингэж дэлхийн гадарга руу ирэхгүй тул арьсны хорт хавдар үүсгэхгүй.

Нарны ХЯТ-ны агаар мандалд нэвтрэх байдал



ХЯТ-ны хүний арьсанд үзүүлэх нөлөө



Нөлөөллийн ангилал ба эрүүл мэндэд үзүүлэх эрсдэл	Хэт Ягаан Туяаны зэрэглэл
Бага	< 2
Дунд зэрэг	3-5
Өндөр	6-7
Хэт өндөр	8-10
Аюултай	11+

Хэт ягаан туяаны байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө

Озоны давхарга цоорсноор



Газрын гадаргад ирэх нарны UV-B туяа нэмэгдэнэ

Хэт ягаан туяа нь үзэгдэх гэрлээс их энергитэй учир амьд организмын эд, эсийг гэмтээх чадвартай.

Нарны гэрлийн нэг бүрэлдэхүүн учир нарны гэрэл тусах бүх гадаргууд хүрч очно. Иймээс хүн, амьтан, ургамал, хүрээлэх орчинд бүгдэд нь янз бүрийн хэмжээгээр нөлөөлнө.

UV-C (290-200 нм) – агаар мандалд бүрэн шингэж, газрын гадаргууд ирдэггүй.

UV-B (320-290 нм) – озоны цоорхойн нөлөөгөөр нэмэгдэж байгаа.

UV-A (400-320 нм) – агаар мандалд бага зэрэг шингээд ихэнх нь газрын гадаргад ирдэг.

Хэт ягаан туяаны байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө

Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө

- Дархлаа сулрах
- Арьсны өвчлөл тэр дундаа хорт хавдрын (меланома) өвчлөл нэмэгдэх
- Нүдний салст бүрхүүл үрэвсэх
- Нүдний болор цайх өвчин (катаракт) нэмэгдэх
- Наранд шарах хугацаа богиносх

Экосистемд үзүүлэх нөлөө


- Ургамлын ургац буурах, давжаарах
- Хүнс, тэжээлийн хомсдол бий болох
- Ойн нөөц хомсдох
- Далайн бичил биетнүүд, түүгээр хооллодог усны ургамал, амьтан хомсдох
- Биологийн төрөл зүйл цөөрөх

Бусад нөлөө

- Байшин барилгын гадаргуу, өнгөлгөөний материал өгөрших
- Нарны ХЯТ-ны шууд усгалд байгаа материалууд хурдан элэгдэж, хэврэгших

ДЭМБ-аас мэдээ:

Хэт ягаан туяаны нөлөөгөөр үүсэх арьсны хорт хавдарын тохиолдлын тоо



Озоны цоорхойн шалтгаан


- 1970-аад оны дундуур эрдэмтэд өмнөд туйл (Антарктид) дээрх озоны давхарга “цоорч” буюу нимгэрч байгааг олж тогтоожээ.
- Озоны задрал нь гол төлөв O_3 молекулыг задалж O_2 болгох урвалд оруулдаг “озон задалдаг бодис” (ОЗБ)-ын агууламжаас шууд хамаарна.
- Эрдэмтэд озоны задрал нь үйлдвэрийн аргаар гаргаж авсан, 1920-оод оноос хөргөлт, агааржуулалт, тусгаарлагч хөөсөнцөр хавтангийн үйлдвэрлэл гэх мэт олон салбарт эрчимтэй ашиглаж эхэлсэн хлортфторт нүүрстөрөгч (ХФН/CFC) төрлийн бодисоос үүсэлтэйг тогтоосон.

ОЗБ болон тэдгээрийг орлуулах бодисууд дараах бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжид өөр өөр зориулалтаар хэрэглэгддэг. Үүнд:

- Хөргөлт, агааржуулалтын төхөөрөмж (*хөргөх бодис - refrigerant*)
- Аэрозоль шүршигч (*пропеллант*)
- Электроникийн эд анги цэвэрлэх уусмал
- Тусгаарлагч хөөсөнцөр хавтангийн үйлдвэр (*хөөсрүүлэгч – blowing agent*)
- Гал унтраагуур (*fire extinguisher*)
- Үнэртүүлэгч хий (*stench gas*)




Дэлхийн озоны давхарга: 1979 он




Зургийн эх сурвалж: https://ozonewatch.gsfc.nasa.gov/ozone_maps/images/

Дэлхийн озоны давхарга: 2000 он



Дэлхийн озоны давхарга: 2017 он




Озоны цоорхой: Өмнөд туйл

Озонтой адилаар ОЗБ-уудын агууламж мөн туйлын хэсэгт хамгийн их байдаг ба нөгөө талаас озон задлах урвал явагдахад маш бага (-78°C-аас доош) температурт бүрэлддэг давхраат мандлын үүл шаардлагатай байдгаас туйлын бүст, тэр дундаа өмнөд туйл дээрх озон хамгийн их задардаг.



Озоны нийт баганын хэмжээг Добсон нэгжээр (Dobson unit) хэмждэг ба баганын озоны хэмжээ 220 Добсон нэгжээс бага байвал тухайн газарт озон цоорсон байна гэж үзэж, нийт талбайг тооцоолдог.

Хамгийн том талбайг хамарсан, мөн хамгийн гүн “цоорхой” 2006 оны 9-10 сард тохиосон байна. Үүнд ОЗБ-ын их агууламжаас гадна Антарктидын онцгой хүйтэн өвөл нөлөөлжээ.



2006 оны 9 сарын 24
Антарктид тив дээрх озон
(Добсон нэгж)

Озоны цоорхой: Өмнөд туйлын озоны давхаргын улирлын өөрчлөлт



Зургийн эх сурвалж: https://ozonewatch.gsfc.nasa.gov/ozone_maps/images/

Олон улсын гэрээ: Монреалийн протокол

- ❖ 1985 онд “Озоны үе давхаргыг хамгаалах Венийн конвенц”,
- ❖ 1987 дээрх конвенцийн “Озон задалдаг бодисын тухай Монреалийн протокол”-ыг тус тус баталсан. 1990 онд Лондон, 1992 онд Копенхаген, 1997 онд Монреаль, 1999 онд Бээжин, 2016 онд Кигали хотод болсон Талуудын хурлуудаар протоколд нэмэлт өөрчлөлт оруулсан.
- ❖ Монгол Улс 1996 онд дээрх конвенц, протоколыг тус тус соёрхон баталж, нэгдэн орсноор Тал улс орон болсон.
- ❖ Энэхүү олон улсын протоколд нэгдэн орж, Тал улс орон болсноор бусад Тал улс орнуудтай худалдаа хийх боломжтой болсон.
- ❖ Тал улс орон Монреалийн протоколоор хүлээсэн үүргээ заавал биелүүлж байх үүрэгтэй бөгөөд эс биелүүлбэл Олон улсын байгууллага- Озоны нарийн бичгийн дарга нарын газраас тухайн оронд хариуцлагын арга хэмжээ авдаг.
- ❖ Монреалийн протоколын үндсэн зорилго:
 - I. Озон задалдаг бодисын үйлдвэрлэл, хэрэглээг хянах буюу үе шаттайгаар бууруулж, хэрэглээнээс халах.
 - II. Дэлхийн дулааралд үлэмж нөлөөтэй хүлэмжийн хийнүүдийн үйлдвэрлэл, хэрэглээг үе шаттай бууруулах.


Олон улсын гэрээ: Монреалийн протокол

- ❖ Тал улс орнуудыг дотор нь *Тавдугаар зүйлийн* (голдуу хөгжиж буй орнууд, МУ мөн энэ бүлэгт багтдаг, **A5**) болон *Тавдугаар зүйлийн бус* (голдуу хөгжингүй орнууд, **non-A5**) гэж хоёр ангилдаг.
- ❖ Монреалийн протоколоор хавсралтад заасан хяналттай бодисын импорт, хэрэглээний хэмжээг хянадаг буюу Монгол улсын импортлох хэмжээг хянана.(= бодис импортлох квот).
- ❖ **2010 онд** Монреалийн протоколын Тавдугаар зүйлийн Тал улс орнууд ГФН/СFC, галонууд (halon), дөрвөн хлорт нүүрстөрөгч (CCl₄)-ийн үйлдвэрлэл, хэрэглээг бүрмөсөн зогсоосон.
- ❖ **2015 онд ГХФН/НСFC төрлийн бодисын үйлдвэрлэл, хэрэглээг суурь түвшнээс 10% бууруулсан ба цаашид үе шаттай бууруулсаар 2030 онд бүр мөсөн хэрэглээнээс халах зорилгоор хянаж ажиллаж байна.**

Монреалийн протоколын зохицуулах арга хэмжээ

Озон задалдаг бодис	Тавдугаар зүйлийн бус Тал улс орнууд (Хөгжилтэй орнууд)	Тавдугаар зүйлийн Тал улс орнууд-МОНГОЛ УЛС (Хөгжиж буй орнууд)
Хлорфторт нүүрстөрөгч (ХФН/СFC)	1996 оны 1 сарын 1 гэхэд үйлдвэрлэл, хэрэглээг зогсоох	2010 оны 1 сарын 1 гэхэд үйлдвэрлэл, хэрэглээг зогсоох
Гидрохлорфторт нүүрстөрөгч (ГХФН/НСFC) R 22 төрлийн бодис	2020 оны 1 сарын 1 гэхэд үйлдвэрлэл, хэрэглээг бүрмөсөн зогсоох	2030 оны 1 сарын 1 гэхэд үйлдвэрлэл, хэрэглээг бүрмөсөн зогсоох
Гидрофторт нүүрстөрөгчийн (ГФН/НСFC) төрлийн бодисууд	2024 оноос үйлдвэрлэл, импортыг үе шаттайгаар бууруулж эхлэнэ	

МУ-ын ГХФН/НСFC төрлийн бодисыг үе шаттай бууруулах хуваарь



	2015	2016	2017	2018	2019	2020
МУ-ын квот (ОЗЧ-тонн)	0.77	0.77	0.77	0.77	0.77	0.4
НСFC-22 бодист оногдох хэмжээ (тонн)	14	14	14	14	14	7.27

Бодис бүрийн **озон задлах чадвар** (ОЗЧ/ODP) нь харилцан адилгүй бөгөөд Монреалийн протоколын хавсралтад багтсан бодисуудын ОЗЧыг CFC-11 бодисынхтой харьцуулан хэмжиж (ОЗЧ_{CFC-11} = 1) тогтоосон байдаг.

Хяналтын арга хэмжээг мөн бодисын ОЗЧ хэмжигдэхүүнд түшиглэн авдаг ба тухайн улсын үйлдвэрлэл (импорт), хэрэглээний квотыг ОЗЧ-тонноор тооцож тогтоодог.

МУ-ын хувьд 2018 онд нийт 0.77 ОЗЧ-тонн бодис импортлох квоттой буюу энэ нь нийт 14 тонн НСFC-22 бодистой тэнцэх хэмжээ юм (ОЗЧ_{НСFC-22} = 0.055).

Хүлэмжийн хий, дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт

- ❖ Дэлхийн дулаарал гэдэг нь дэлхийн уур амьсгалын дундаж температур урт хугацааны дунджаас нэмэгдэж хэлэх ба одоо явагдаж байгаа дулаарлын голлох шалтгаан нь хүний үйл ажиллагааны үр дүнд бий болсон хүлэмжийн хийний их хэмжээний ялгарал юм.
- ❖ Дэлхийн дулаарал уур амьсгалыг өөрчилж, дэлхийн экосистемийн тэнцвэрийг алдагдуулж байна.
- ❖ Хамгийн их ялгарлыг чулуужсан түлшний хэрэглээнээс бий болох нүүрсхүчлийн хий (CO_2)-ний ялгарал эзлэх боловч нөгөөтэйгүүр **дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар** (ДДНЧ/GWP) маш өндөртэй олон төрлийн химийн бодисыг хүн төрөлхтөн үйлдвэрийн аргаар гарган авч хэрэглэсээр байна.
- ❖ Монреалийн протоколын хавсралтад орсон бодисуудын ДДНЧ-ыг CO_2 бодисынхтой харьцуулан хэмжиж ($\text{ДДНЧ}_{\text{CO}_2} = 1$), уг хэмжигдэхүүнийг Монреалийн протоколын хавсралтуудад нэмж тусгасан.



Дэлхийн дулаарал: Шууд ба шууд бус нөлөөллүүд

- Газрын гадаргын температур нэмэгдэх
- Мөсөн бүрхэвчүүд хайлах (Хойд туйл, Гренланд, Исланд, Өндөр уулын оргилууд, гэх мэт.)
- Далайн түвшин нэмэгдэх
- Далайн усны рН өөрчлөгдөх, экосистемд өөрчлөлт орох
- Далайн усны давсны агууламж, температур өөрчлөгдсөнөөс үүдэн дэлхийн хэмжээний далайн усны урсгалын горимд өөрчлөлт орох
- Дэлхийн хэмжээний агаарын урсгалын горимд өөрчлөлт орох (цаг уурын үзэгдэлд шууд хамааралтай)
- Байгалийн аюулт үзэгдлийн давтамж нэмэгдэх (хар салхи, үер, ган, зуд, хэт их халуун, хэт их хуурайшил, түймэр, гэх мэт.)
- Зарим амьтдын амьдрах орчин нөхцөлд өөрчлөлт орсноор устаж үгүй болох, цөөрөх, шилжин нүүх аюул
- Уур амьсгалын өөрчлөлт нь зарим бүс нутаг дахь хүний амьдрах таатай орчныг үгүй болгож, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй экосистемд гарч буй өөрчлөлт, байгалийн гамшигт үзэгдэл, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хүчин чармайлт зэрэг нь хүн төрөлхтний хувьд эдийн засгийн асар их хохирол дагуулж байна.

Кигалийн нэмэлт өөрчлөлт (2016)

- ❖ 2016 онд Руанда улсын Кигали хотноо болсон Талуудын хурлаар Монреалийн протоколд нэмэлт өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн.
- ❖ Уг нэмэлт өөрчлөлтөөр ГФН/НФС төрлийн хөргөх бодисуудыг Монреалийн протоколын хяналтад оруулсан ба эдгээр нь озон задлах чадваргүй ч ($\text{ОЗЧ}=0$) дэлхийн дулааралд нөлөөх чадвар өндөртэй хүлэмжийн хийнүүд юм.
- ❖ Энэхүү нэмэлт өөрчлөлтийг оруулснаар дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад хувь нэмэр оруулна.
- ❖ Нэмэлт өөрчлөлтийн үндсэн агуулга :
 - Дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй ГФН/НФС төрлийн хөргөх бодисуудыг үе шаттайгаар бууруулах хуваарийг баталсан .
 - Монреалийн протоколын хавсралтад багтсан бодисуудын ДДНЧ утгуудыг нэмж оруулсан ба үүнд үндэслэн Тал улс орнууд ГФН/НФС төрлийн бодисын үйлдвэрлэл (импорт), хэрэглээг тооцоолохдоо CO_2 -эквивалент тонн нэгжийг ашиглана.
 - Энэ хэмжигдэхүүн нь тухайн бодис CO_2 хийтэй харьцангуй дэлхийн дулааралд хэр нөлөөлөхийг илэрхийлнэ.

Кигалийн нэмэлт өөрчлөлт

Монреалийн протоколын F хавсралтад багтсан бодисууд болон тэдгээрийн ДДНЧ утгыг хүснэгтэд үзүүлэв. Хавсралтад багтсан бодисуудыг үе шаттай бууруулах хуваарийг Талс улс орнуудын 4 бүлэгт зориулан гаргасан. Үүнд:

Тавдугаар зүйлийн Тал улс орнууд:

- Бүлэг 1: Тавдугаар зүйлийн Тал улс орнуудын дийлэнх олонхи (*Монгол улс багтана*)
- Бүлэг 2: Бахрейн, Энэтхэг, Иран, Ирак, Кувейт, Оман, Пакистан, Катар, Саудын Араб, Арабын Нэгдсэн Эмират Улс. (*Хэт халуун уур амьсгалтай орнууд*)

Тавдугаар зүйлийн бус Тал улс орнууд:

- Бүлэг 1: Тавдугаар зүйлийн бус Тал улс орнуудын дийлэнх олонхи
- Бүлэг 2: Беларусь, ОХУ, Казакстан, Тажикстан, Узбекстан

F хавсралт	Бодис	ДДНЧ (GWP)
Бүлэг I	HFC-134	1100
	HFC-134a	1430
	HFC-143	353
	HFC-245fa	1030
	HFC-365mfc	794
	HFC-227ea	3220
	HFC-236cb	1340
	HFC-236ea	1370
	HFC-236fa	9810
	HFC-245ca	693
	HFC-43-10mee	1640
	HFC-32	675
	HFC-125	3500
	HFC-143a	4470
	HFC-41	92
HFC-152	53	
HFC-152a	124	
Бүлэг II	HFC-23	14800


Кигалийн нэмэлт өөрчлөлт: ГФН/НFC бодисыг үе шаттай бууруулах хуваарь (A5- Монгол)

	Тавдугаар зүйлийн Тал улс орнууд: Нэгдүгээр бүлэг- МОНГОЛ УЛС	Тавдугаар зүйлийн Тал улс орнууд: Хоёрдугаар бүлэг
Суурь түвшинг тооцоолох онууд	2020, 2021, 2022	2024, 2025, 2026
Суурь түвшинг тооцоолох арга	2020, 2021, 2022 онуудын HFC-ийн үйлдвэрлэл/хэрэглээний дундаж дээр HCFC-ийн үйлдвэрлэл/хэрэглээний суурь түвшний 65% -ийг нэмж тооцох	2024, 2025, 2026 онуудын HFC-ийн үйлдвэрлэл/хэрэглээний дундаж дээр HCFC-ийн үйлдвэрлэл/хэрэглээний суурь түвшний 65%-ийг нэмэх тооцох
Бууруулах үе шат Суурь түвшин тогтоох	2024	2028
Алхам 1	2029 10%	2032 10%
Алхам 2	2035 30%	2037 20%
Алхам 3	2040 50%	2042 30%
Алхам 4	2045 80%	2047 85%

Кигалийн нэмэлт өөрчлөлт: ГФН/НFC бодисыг үе шаттай бууруулах хуваарь (non-A5)

	Тавдугаар зүйлийн бус Тал улс орнууд (Үндсэн бүлэг)	Тавдугаар зүйлийн бус Тал улс орнууд: Беларусь, ОХУ, Казакстан, Тажикстан, Узбекстан
Суурь түвшинг тооцоолох онууд	2011, 2012, 2013	2011, 2012, 2013
Суурь түвшинг тооцоолох арга	2011, 2012, 2013 онуудын HFC-ийн үйлдвэрлэл/хэрэглээний дундаж дээр HCFC-ийн үйлдвэрлэл/хэрэглээний суурь түвшний 15%-ийг нэмж тооцох	2011, 2012, 2013 онуудын HFC-ийн үйлдвэрлэл/хэрэглээний дундаж дээр HCFC-ийн үйлдвэрлэл/хэрэглээний суурь түвшний 25%-ийг нэмж тооцох
Бууруулах үе шат		
Алхам 1	2019 10%	2020 5%
Алхам 2	2024 40%	2025 35%
Алхам 3	2029 70%	2029 70%
Алхам 4	2034 80%	2034 80%
Алхам 5	2036 85%	2036 85%

Орлуулах технологи: Шинэ төрлийн хөргөх бодис



- Озон задалдаг бодисоос ялгаатай нь түүнийг орлуулах бодисууд илүү их химийн идэвхтэй учир тэдгээртэй ажиллах аюулгүй ажиллагааны горимд анхаарал хандуулах шаардлагатай.
- ГХФН/HCFC-ийг орлуулах бодисууд шатамхай, хортой, өндөр даралттай зэрэг чанаруудын аль нэгийг эсвэл хамтаар нь агуулж байна.
- Өмнөх үеийн ХФН/CFC, ГХФН/HCFC төрлийн бодисоос ялгаатай учир хөргөх бодистой харьцдаг техникийн ажилтнуудыг мэдээллээр хангаж, чадваржуулах шаардлагатай.

Зурагын эх сурвалж: Safe use of HCFC alternatives in Refrigeration and Air-conditioning (UNEP, 2015)

Орлуулах технологи: Хөргөлт, агааржуулалтын салбарт ОУ-ын баримтлаж буй зарчим

- Эрчим хүчинд хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй хөргөлт, агааржуулалтын тоног төхөөрөмж хэрэглэх.*
 - Тоног төхөөрөмжийн эрчим хүчний хэрэглээнээс хүлэмжийн хийн **шууд бус ялгарал** бий болно.
 - Эрчим хүч бага хэрэглэдэг (energy efficiency өндөр), ОЗЧ=0 болон ДДНЧ багатай хөргөх бодис бүхий тоног төхөөрөмж сонгох шаардлагатай.
- Хөргөлт, агааржуулалтын салбарын засвар үйлчилгээг сайжруулах.*
 - Тоног төхөөрөмжийн битүүмж алдагдах, хөргөх бодистой буруу харьцах, түүнийг зохистой хадгалах, устгах горим алдагдсанаас болж агаар мандалд **шууд ялгарахаас сэргийлэх**.
 - Шинэ үеийн ОЗЧ=0, ДДНЧ багатай орлуулах хөргөх бодисууд **шатамхай, хортой, өндөр даралттай** зэрэг шинж чанартай.
 - Аюулгүй ажиллагааны хувьд өмнөх үеийн ХФН/CFC, ГХФН/HCFC төрлийн хөргөх бодисоос ялгаатай учир энэ чиглэлийн техникийн ажилтнуудыг зохих сургалтанд хамруулж, **гэрчилгээжүүлэх** хэрэгцээ, шаардлага бий болж байна.

Анхаарах асуудлууд

- Зарим өндөр хөгжилтэй орнууд болон Европын холбооны орнууд ОЗЧ-тай бодисын үйлдвэрлэл, хэрэглээг бүр мөсөн хорьж, ДДНЧ өндөртэй бодисыг бууруулах арга хэмжээг аль хэдийн авч эхэлсэн.
- Монгол улс хөргөх бодис (Монреалийн протоколын хавсралтад багтсан болон орлуулах бодисууд) болон тэдгээрийг агуулдаг тоног төхөөрөмжийн дийлэнхийг БНХАУ-аас импортолдог.
- Зөвхөн Монреалийн протоколд заасан хугацаанд анхаарахаас илүү импортлогч орны хувьд гадаад орнууд, тэр дундаа БНХАУ-ын зах зээлийн чиг хандлагыг анхаарах нь чухал юм.
- Удахгүй үйлдвэрлэхийг бүр мөсөн хориглох гэж байгаа бодис, тоног төхөөрөмжийг урьдчилан судалж, тэдгээрийн импортыг бууруулахгүй бол гадаадын улс орны зах зээлээс шахагдсан бүтээгдэхүүн манайд ихээр орж ирэх магадлалтай. Тус тоног төхөөрөмжүүд, мөн тэдгээрт суурилсан үйлдвэр цөөхөн жилийн настай болж, хэрэглэгч, ААНБ алдагдал хүлээх эрсдэлтэй.
- Томоохон барилга, орон сууцны агааржуулах системийн ажлыг гүйцэтгэгч байгууллагууд суурилуулж буй төхөөрөмж, системээ сайтар судлах. Олон арван жилийн турш засвар үйлчилгээ хийх боломжтой технологи сонгох (Жишээ нь HCFC-22 бодисоор ажилладаг агааржуулагч төхөөрөмжүүдийг хэдхэн жилийн дотор цэнэглэх боломжгүй болно).
- Хэрэв тухайн бүтээгдэхүүн **аюултай хог хаягдлын жагсаалтад** орвол импортлогч өөрөө давхар хариуцлага хүлээх хэрэгтэй болно. Байгаль орчинд сөрөг нөлөөтэй бодис, түүнийг агуулсан цахилгаан (электрон) тоног төхөөрөмжүүд ийм жагсаалтад хамрагдах магадлалтай.

ОЛОН УЛСЫН ХӨРГӨЛТ, АГААРЖУУЛАЛТ, ХӨӨСӨНЦРИЙН САЛБАРТ АШИГЛАЖ БУЙ ОРЛУУЛАХ ТЕХНОЛОГИЙН ӨНӨӨГИЙН ЧИГ ХАНДЛАГА


Ms. Liazzat Rabbiosi

Programme Officer

OzonAction - Montreal Protocol

Asia and the Pacific Office

www.unep.org



- NASA-ийн сүүлийн үеийн мэдээнээс үзэхэд 2005-2016 онд озоны хомсдол 20%-иар багассан байна.
- Олон улс даяар соёрхон баталсан цорын ганц Олон талт байгаль орчны гэрээ хэлэлцээр юм.

**Монреалийн протокол:
Озон задалдаг бодис (ОЗБ)-ыг
амжилттай бууруулж байна**

Видео: [Озон задалдаг бодис \(ОЗБ\)-ыг бууруулж байна](#)

Гол амжилтууд:



2030 он гэхэд жил бүр арьсны хорт хавдрын 2 сая хүртэлх тохиолдлоос урьдчилсан сэргийлэх боломжтой




Зөвхөн хөдөө аж ахуй, загас агнуур, бараа материалын салбарт 1987-2060 оны хооронд учирч болох хор хохирлоос урьдчилан сэргийлснээр 460 тэрбум ам.доллар хэмнэх боломжтой.



Олон талт сан 1991 оноос хойш хөгжиж буй орнуудад нийт 3.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийсний үр дүнд Монреалийн протокол нь технологийн шилжилт хийсэн.

Хөргөх бодисын шилжилт


- Монреалийн протоколын дагуу олон улсын болон үндэсний бодлого, зохицуулалтад халаалт, агаар сэлгэлт, агааржуулалт, хөргөлт (HVACR)-ийн салбар хамгийн ихээр өртөж байна.



Дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар (ДДНЧ) өндөртэй озон задалдаг бодисууд

ДДНЧ ихтэй эсвэл ДДНЧ-гүй озон задалдаггүй бодисууд

Монреалийн протоколын дагуу хянадаг




Тавдугаар зүйл (A5)-ийн Тал улс орнуудад HVACR-ийн 2 төрлийн зах зээл бий



Хөргөлт, агааржуулалт (RAC)-ын салбарын зах зээлийн өсөлт

Дэлхийн нийт хэрэгцээ ≈ 2016 онд 92.46M иж бүрдэл


RAC-ын эрэлт хэрэгцээ бүс нутгаар 2011-2016 он



Source: JRAIA

- Дэлхий нийтийн агааржуулагч төхөөрөмжийн эрэлт хэрэгцээ дунджаар 3%-иар өсөж байна:
 - ⇒ Эдийн засгийн хөгжил
 - ⇒ Эд баялагийн өсөн нэмэгдэлт
 - ⇒ Уур амьсгалын өөрчлөлт
- Ази, Номхон далайн бүс нутаг нь Өмнөд Азийн томоохон эрэлт хэрэгцээтэй хамт HVACR-ийн голлох зах зээл байх болно
- ГХФН/НСFC төрлийн бодисын бууралт, HVACR-ийн салбарын өсөлт нь ГФН/НСFC-ийн хэрэглээг жолоодож байна.
- ГФН/НСFC-ийн хяналтгүй хэрэглээ нь ГХФН/НСFC-ийг хэрэглээнээс халснаар байгаль орчинд үзүүлэх эерэг нөлөөг үгүй хийх эрсдэлд хүргэж байна. Жнь. R-410A vs HCFC-22

Дэлхий даяар ГХФН/НСFC-ийг үе шаттай бууруулах зорилт ба ГФН/НСFC-ийн хэрэглээ




- Дэлхий даяар ГХФН/НСFC-ийг үе шаттай бууруулах ажиллагаа НРМР-ийн II үе шатад шилжиж байна.
- МП-ын хэрэгжилт, RAC салбарын өсөлт нь ГФН/НСFC-ийн хэрэглээг нэмэгдүүлж байна.
- ГФН/НСFC-ийг хяналтад оруулах Кигалийн нэмэлт өөрчлөлт
- Дэлхий нийтээр ГФН/НСFC-д арга хэмжээ авснаар температурын өсөлтийг 0.5°C-аар бууруулах боломжтой.

Эх сурвалж: Gluckman Consulting

© 2015 UN Environment Programme. All rights reserved. Reproduction, distribution, and sale in any form or by any means without the prior written permission of the United Nations Environment Programme are prohibited.


ГФН/НСFC төрлийн бодисын дэлхийн хэрэглээ

- R-134a
- R-125
- R-32
- R-143a
- R-152a
- Other HFCs



Эх сурвалж: "UNEP Ozone Secretariat Fact Sheet 2, Overview of HFC Market Sectors" (Oct 2015)


- R-410A (R-125/R-32 хольц) – агааржуулагч төхөөрөмжид ашиглаж буй голлох ОЗБ-ыг орлуулах бодис
- R-134a & R-404A – голдуу хөргөлтийн салбарт ашиглагддаг ОЗБ-ыг орлуулах бодис



Салбар	Гол HFC	ДДНЧ
RACHP	R-404A	3922
	R-410A	2088
	R-407C	1774
	HFC-134a	1430
Аэрозоль	HFC-134a	1430
	HFC-152a	124
	HFC-227ea	3220
Хөөсөнцөр	HFC-134a	1430
	HFC-245fa	1030
	HFC-365mfc / HFC-227ea	960 - 1100
Гал унтраагуур	HFC-227ea	3220
	HFC-125	3500
	HFC-23	14800
Уусгагч	HFC-431mee	1640

Хөргөх бодисын технологийн чиг хандлага

Өмнөд Азийн орнуудын ОЗБ-ыг орлуулах бодисын импортод HFC болон HFC-ээс бусад бодисын эзлэх хувь



- Энэхүү тоо баримтад Өмнөд Азийн Сүлжээний Энэтхэг, БНХАУ, Иран, БНСУ, БНАСАУ зэрэг орнууд багтаагүй
- Эх сурвалж: Озоны Нарийн бичгийн дарга нарын газар & ОЗБ-ыг орлуулах бодисын судалгаа, UNEP

- ОЗБ-ууд нь голдуу HCFC-22, HCFC-141b, HCFC-142b зэрэг ГХФН/HCFC төрлийн бодисууд
- ГФН/HFC-ид суурилсан ОЗБ-ыг орлуулах гол бодисууд нь R-410A, HFC-134a, R-404A, R-407C
- HFC-д суурилагүй ОЗБ-ыг орлуулах бодисууд голдуу нүүрсустөрөгч (R-600a, R-1270)-ид, аммиак, CO₂ зэрэг болно.

Технологийн сонголт


Автомашинь АС	Ахуйн хөргөх төхөөрөмж	Худалдааны хөр/төх.	Үйлдвэрийн хөр/төх.	Агааржуулагч	Хөөсөнцөр
CO₂, (HC) R1234yf	HC	CO₂, NH₃, HC	NH₃, HC R32	HC, NH₃	CO₂, HC

Технологийн сонголтын шалгуур үзүүлэлт – ДДНЧ багатай технологид шилжиж байна





Төгс хөргөх бодис байхгүй юу?



БНХАУ-ын чиг хандлага

Орлуулах хөргөх бодистой холбоотой хэд хэдэн орлуулах шийдэл бий

- ✓ RAC салбарын хувьд R-290 бол ирээдүйн сонголт. Хятадын олон компани R-290 бодисын үйлдвэрлэлийн шугамыг аль хэдийн байгуулаад байна.
- ✓ Худалдааны HPWH (heat pump water heater) салбарын хувьд R-290, R-744 бодистой технологиуд хөгжиж байна.
- ✓ Автомашины/хөдөлгөөнт агааржуулагчийн салбарын хувьд R-744 нь ирээдүйн сонголт. Томоохон машин үйлдвэрлэдэг компаниуд R-744-т шилжиж байна (Benz, Audi, Ford, KIA and Volkswagen г.м.).
- ✓ HFO-1234yf гэх мэт шинэ нийлмэл хөргөх бодисуудын хувьд автомашины агааржуулагчийн хөргөх бодис болох боломжтой.

ДДНЧ багатай технологийг сурталчлах бодлогын арга хэмжээ

Бодлого, зохицуулалт:
 -**Нийлүүлэлт:** Эрчим хүчний хэрэглээг хуульчлах (RAC төхөөрөмж заавал баримтлах, Эко-шошго), хөргөх бодисыг оролцуулсан Эрчим хүчний хамгийн бага хэрэглээний стандарт (Minimum Energy Performance Standard)
 -**Эрэлт хэрэгцээ:** Барилгын дүрэм, журам, нийтийн худалдан авалт

Хэрэглэгчдийн мэдлэгийг дээшлүүлэх

Чадамжийн түвшин:
 - Чадамжтай (гэрчилгээтэй) RAC техникийн ажилтан



Stakeholders Consultation on Certification System for RAC Servicing Sector Technicians • Ulaanbaator, Mongolia • 8 June 2018

Баярлалаа



Ms. Liazzat Rabbiosi
 Programme Officer
 OzonAction - Montreal Protocol
 Asia and the Pacific Office
www.unep.org



ХӨРГӨЛТ, АГААРЖУУЛАЛТЫН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНИКИЙН АЖИЛТНУУДЫН ЧАДАМЖ ХЭР ЧУХАЛ ВЭ?

Техникийн ажилтнуудын чадамжийг баталгаажуулах,
гэрчилгээжүүлэх нь яагаад чухал вэ?

БОАЖЯ-ны Озоны үндэсний албаны ахлах мэргэжилтэн,
төслийн нэгжийн зохицуулагч Д.Дуламсүрэн

ХӨРГӨЛТ, АГААРЖУУЛАЛТЫН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНИКИЙН АЖИЛТНУУДЫГ ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ ТОГТОЛЦОО НЭВТРҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААРХ
ҮНДЭСНИЙ ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ

2018 оны 06 дугаар сарын 08

Улаанбаатар зочид буудал, "Хөх асар" танхим

HCFC хөргөх бодисыг үе шаттай бууруулах тухай шийдвэр, хугацаа


2007 онд хуралдсан “Озоны давхаргыг хамгаалах конвенц”-ийн Монреалийн протоколын Талуудын ээлжилт бага хурлаас дэлхийн дулааралд үлэмж нөлөөтэй гидрохлорфторт нүүрстөрөгчийн /HCFC/ төрлийн бодисуудыг 2030 он хүртэл үе шаттай бууруулах олон улсын дараахи шинэ стратегийг тодорхойлсон. Үүнд:

А. 2015 онд 10%

Б. 2020 онд 35%

В. 2025 онд 67,5%-иар тус тус үе шаттайгаар бууруулахаар тогтсон болно.

Хөгжиж буй орнуудад HCFC-ийн төрлийн бодисуудыг бүрмөсөн зогсоох хуваарь



Монгол улсын HCFC* хөргөх бодисыг үе шаттай бууруулах хөтөлбөрийн зорилго

“Гидрохлорфторт нүүрстөрөгч (HCFC) хөргөх бодисыг үе шаттай бууруулах менежментийн хөтөлбөр”-ийн эхний шатанд **HCFC хөргөх бодисыг 2020 гэхэд 35 хувь бууруулна.**

Хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлэх арга замаар **Монгол улсад HCFC хөргөх бодисын импорт/хэрэглээг 2030 он гэхэд бүрмөсөн зогсоох,** Монреалийн протоколоор хүлээсэн үүрэг амлалтыг биелүүлэх зорилготой.


Монгол улсын HCFC хөргөх бодисыг үе шаттай бууруулах менежментийн хөтөлбөр” –ийг НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр хяналт тавьж, Япон улсын Засгийн газар хамтран хэрэгжүүлэх агентлагаар тогтсон.

Hydrochlorofluorocarbons (HCFCs)*

Монреалийн протоколоор Монгол улсын HCFC бодисыг үе шаттайгаар бууруулах хуваарь

Хөгжиж буй орнуудын Монреалийн протоколын дагуу бууруулах хугацаа	Монгол улсын HCFC бодисыг үе шаттайгаар бууруулах үүрэг
2009-2010 оны импорт/хэрэглээний дундаж	Суурь түвшин
2013 оны 01 дүгээр сарын 01	HCFC бодисын хэрэглээг 2009-2010 оны хэрэглээний түвшинд тогтоон барих/зарцаах
2015 оны 01 дүгээр сарын 01	Суурь түвшингээс 10 хувь бууруулах
2020 оны 01 дүгээр сарын 01	Суурь түвшингээс 35 хувь бууруулах
2025 оны 01 дүгээр сарын 01	Суурь түвшингээс 67.5 хувь бууруулах
2030 оны 01 дүгээр сарын 01	Суурь түвшингээс 100 хувь бүрмөсөн зогсоох

ХӨРГӨЛТ, АГААРЖУУЛАЛТЫН САЛБАР



НСFC ТӨРЛИЙН БОДИСЫН МОНГОЛ УЛСЫН ХЭРЭГЛЭЭ

Худалдааны болон үйлдвэрлэлийн зориулалттай хөргөлт, агааржуулалтын тоног төхөөрөмжүүд


- HCFC-22

Хөөсөнцрийн үйлдвэрт түүхий эд хэлбэрээр ашигладаг.

- HCFC-22

Хөөсөн шахмал полистирол (XPS) бүтээгдэхүүний үйлдвэрт
Хэрэглээний хэмжээ нь харьцангуй бага боловч улс орны протоколоор хүлээсэн үүргээ биелүүлэхэд саад болох учир технологийн шинэчлэлт яаралтай хийх шаардлагатай байсан.

Монгол улсад НСFC хэрэглээг бууруулах зорилт (2030 он хүртэл)



НСFC хөргөх бодисын менежментийн хөтөлбөрийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- НСFC хөргөх бодисын талаарх бодлого, дүрэм журмыг бэхжүүлэх
- Озон задалдаг бодис болон НСFC бодисыг хилийн боомтууд дээр таних, хянах талаар гаалийн байгууллагын ажилтануудын мэдлэг чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн цуврал сургалтууд зохион байгуулах;
- **Хөргөлт, агааржуулалтын засвар үйлчилгээний техникийн ажилтануудын чадавхийг дээшлүүлэх сургалтын төв байгуулахад санхүүгийн дэмжлэг авах, сургалтууд зохион байгуулах;**
- Хөргөлтийн техникийн импорт, үйлчилгээний салбарын ажилтан нарын чадавхийг дээшлүүлэх сургалтын төв байгуулахад санхүүгийн дэмжлэг авах, холбогдох сургалтууд зохион байгуулах;
- НСFC хөргөх бодис ашиглан үйлдвэрлэдэг барилгын дулаан тусгаарлах шахмал хөөсөн полистирол (XPS) хавтан үйлдвэрлэлийн шугамыг НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн болон Япон улсын ЗГ-ын зардлаар өөрчилж, шинэчлэн тоноглох;
- НСFC бодисыг бууруулах талаар мэдээлэл, сурталчилгааны өргөн хүрээтэй компанид ажил явуулах зэрэг болно.

HCFC хөргөх бодисын талаарх бодлого, дүрэм журмыг бэхжүүлэх шинэчлэл

2012 Байгаль орчны багц хуулиудын төслийн “Агаарын тухай” хуулийн нэмэлт	Агаарын тухай хуулийн 25.2-ын дагуу озон задалдаг бодис болон орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийн тоо хэмжээг /квот/ жил бүр Байгаль орчны асуудал эрхлэсэн төрийн захиргааны төв байгууллага батлаж тусгай зөвшөөрөл олгож байхаар тусгасан нь тоо, хэмжээг хууь ёсны болгов. Байгаль орчны багц хуулиудын төслийн “Агаарын тухай” хуулийн нэмэлт, өөрчлөлтөд озоны давхаргыг хамгаалах талаарх 25 дугаар зүйлийг оруулсан нь батлагдав.
2012-2015 онд “Озон задалдаг бодисыг импортлох, худалдаалах, ашиглах журам”-ыг	“Озон задалдаг бодисыг импортлох, худалдаалах, ашиглах журам”-ыг (ЗГ-ын 104 тогтоол) шинэчлэн боловсруулж ЗГ-т өргөн барив.
2012 оны 12 сард ЗГ-ын 145 дугаар тогтоол	Монгол улсад хэрэглэхийг хориглосон буюу хязгаарласан химийн бодисын жагсаалт-д 93-126 дугаарт 34 төрлийн HCFC бодисыг нэмэлтээр
2011 оны Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн нэмэлт
2013 оны 8 дугаар сарын 23-ны ЗГ-ын 303 дугаар тогтоол	<ul style="list-style-type: none"> • R-290 (Propane) • R-32 (Difluoromethane) • R-152a (Difluoroethane) • R-744 (Carbon dioxide) бүхий хөргөх бодистой хөргөлтийн тоног төхөөрөмж импортлосон бол аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.1.8 – т заасан хөнгөлөлт эдлэнэ*.
2014 оны ЗГ-ын 374 дугаар тогтоол	HCFC-22 болон HCFC-141b бодис бүхий хөөсөнцөр үйлдвэрлэх тоног төхөөрөмжийг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон кодлосон барааны жагсаалтад нэмэлт оруулах тухай 2014 оны ЗГ-ын 374 дугаар тогтоол

HCFC хөргөх бодисын талаарх бодлого, дүрэм журмыг бэхжүүлэх шинэчлэл

- Хөргөлтийн болон агааржуулалтын засвар үйлчилгээний техникчдийг сертификатжуулах болон лиценцжүүлэх систем нэвтрүүлэх хүрээнд
- 2017 оны 4-р сарын 6-ны өдөр Стандартчиллын үндэсний зөвлөлийн ээлжит хуралдаанаар “MNS EN 13313:2017 Хөргөлтийн систем болон дулааны насос – Ажилтны ур чадвар” стандартын төслийг улсын хэмжээнд хэрэглэхээр хүлээн зөвшөөрч үндэсний стандартаар батлуулсан.



Хөргөлт, агааржуулалтын засвар үйлчилгээний техникийн ажилтануудын чадавхийг дээшлүүлэх сургалтын төв байгуулахад санхүүгийн дэмжлэг авах, сургалтууд зохион байгуулах

“Мастер чадамж” сургалтын төвийг хөтөлбөрийн хүрээнд байгуулав.



Чадавхжуулах сургалт: 2012.05 - 2018.04 сар хүртэл нийт 200 гаруй техникчдэд озон задалдаг бодис тэдгээрийг оруулах бодис ашиглан зөв зохистой засвар үйлчилгээ хийх чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, сургалтанд хамрагдсан гэрчилгээ олгов.



Техникийн тусламж

- НҮБ-ын БОХ-ийн санхүүжилтээр 2013 онд 14,905,630.38 ам.доллар, 2015 онд 4,325.00 ам.долларын үнэ бүхий 30 -иад нэр төрлийн багаж, тоног төхөөрөмжийг дагалдах хэрэгсэлийн хамт хүлээлгэн өгөв.

Хөргөлт, агааржуулалтын засвар үйлчилгээний техникийн ажилтануудын чадавхийг дээшлүүлэх сургалтын төв байгуулахад санхүүгийн дэмжлэг авах, сургалтууд зохион байгуулах




Олон улсын сургалт

- МХХАХ болон "Мастер Чадамж" сургалтын төвийн 10 гаруй ажилтаныг
- 2012 онд Япон
- 2013 онд Тайланд
- 2015 онд Малайз
- 2017 онд Япон
- БНХАУ улсад зохион байгуулагч талын зардлаар сургалтанд хамруулж хөргөлт, агааржуулалтын техник, технологид озон-уур амьсгалд ээлтэй орлуулах бодис ашиглаж буй дэлхийн туршлагаас судлуулж, чадавхийг бэхжүүлэв


НСFC ТӨРЛИЙН ОЗОН ЗАДАЛДАГ БОДИСЫН ИМПОРТЫН ХЭМЖЭЭ (2012-2016)

Бодисын төрөл	Бодисын хэмжээ, тн						Нийт озон задлах чадвар (тн)	Нийт CO ₂ (экв тн)
	2012	2013	2014	2015	2016	Нийт		
HCFC-22	52.170	16.153	6.848	11.544	8.185	94.899	5.219	171767.371
R-406A	0.045	0.127	0.075	0.036	-	0.283	0.018	536.750
HCFC-141b	-	-	2.270	-	-	2.270	0.250	1645.750
Нийт, тн	52.215	16.280	9.193	11.580	8.185	97.452	5.488	173949.871

НСFC төрлийн озон задалдаг бодисын импортын хэмжээний бууралт (2012-2016)



МОНРЕАЛИЙН ПРОТОКОЛЫН ОЗБ-ООС ТАТГАЛЗАХ СТРАТЕГИ




HCFC төрлийн бодисыг орлуулах бодис

HFC		HC	
<ul style="list-style-type: none"> Озон задлах чадваргүй (ODP=0) Дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөр (GWP=High) 		<ul style="list-style-type: none"> Озон задлах чадваргүй (ODP=0) Дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар бага (GWP=Very low) 	
Түгээмэл хэрэглэгддэг HFC бодис	ДДНЧ / GWP (100 жил)	Түгээмэл хэрэглэгддэг HC бодис	ДДНЧ / GWP (100 жил)
R-134a	1360	R-744 (CO ₂)	1
R-227ea	3220	R-717 (Аммиак)	0
R-152a	124	R-290 (Пропан)	3
		R-600a	3


HCFC төрлийн бодисыг орлуулах бодис

HFC		HC
<p>HFC-134a</p>  <p>Ахуйн хөргөгч, хөлдөөгч</p> <p>Автомашинь агааржуулах төхөөрөмж</p>	<p>R-744 (CO₂)</p> 	
<p>HFC-227ea</p>  <p>Гал унтраагуур</p>	<p>HFC-152a</p>  <p>XPS хөөсөнцийн үйлдвэр</p>	
	<p>R-290 (Пропан)</p> 	

HFC бодисын Дэлхий нийтийн хэрэглээ




HFC бодисын Дэлхий нийтийн хэрэглээний салбар



HCFC төрлийн бодисыг орлуулах бодисын Монгол улсын хэрэглээ

HCFC ТӨРЛИЙН ОРЛУУЛАХ БОДИСЫН ИМПОРТЫН МЭДЭЭ (2012-2015)



Он	ГФН(НFC)-ийн төрлийн бодисын нийт хэмжээ, тн
2012	3.97
2013	10.7
2014	17.1
2015	10.1

- 2012-2015 онд 6 төрлийн HFC бодис импортоор орж ирсэн байна.
- HFC-134a хамгийн их
- Импорт хэмжээ 2012-2015 он хүртэл өссөн, буурсан үзүүлэлттэй байна.

HCFC төрлийн бодисыг орлуулах бодисын Монгол улсын хэрэглээ

НС буюу ДДНЧ БАГАТАЙ ОРЛУУЛАХ БОДИСЫН ИМПОРТЫН МЭДЭЭ



Он	ДДНЧ багатай бодисын хэмжээ, тн
2012	346.68
2013	409.09
2014	708.05
2015	2970.4

- 2012-2015 онд 5 төрлийн ДДНЧ багатай орлуулах бодис импортоор орж ирсэн байна.
- R-704, R-744 хамгийн их
- Бодисуудын импортын хэмжээ 2012-2015 он хүртэл өссөн, буурсан үзүүлэлттэй байна.

HFC бодисын Монгол улсын хэрэглээ


HFC ТӨРЛИЙН ОРЛУУЛАХ БОДИСЫН ӨНӨӨГИЙН ХЭРЭГЛЭЭ

Салбар	Хэрэглээний салбар	ГФН (HFC) төрлийн бодис
Хөргөлт	Гэр ахуйн хөргөлт	HFC-134a, R-413a
	Худалдааны хөргөлт	R-404A, R-508B, R-508A, R-507, R-410A
	Томоохон хөргөлтийн системүүд	HFC-134a, R-404A,
	Үйлдвэрийн хөргөлт	HFC-134a
	Хөргөлттэй тээвэр	HFC-134a, R-404A
Агааржуулалт	Бусад агааржуулалт /including split, multi-split and variable refrigerant flow systems, ducted and package rooftop/	HFC-134a, R-407C, R-410A
	Хөдөлгөөнт агааржуулагч	HFC-134a
XPS хөөсөнцөр үйлдвэрлэл		HFC-152a
Аэрозол(MDI инглятор)		HFC-134a
Гал унтраах хэрэгсэл		HFC-125

5 салбарт нийт 21 төрлийн орлуулах бодис ашиглагдаж байна.


HFC бодисын Монгол улсын хэрэглээ

HFC ТӨРЛИЙН ОРЛУУЛАХ БОДИСУУДЫН 2012-2015 ОНЫ ХЭРЭГЛЭЭНИЙ САЛБАРУУД



- Агааржуулалтын салбарт нийт хэрэглээний 88-93% буюу хамгийн их хэрэглээтэй салбар
- Автомашин агааржуулалтын HFC-134a бодис хамгийн их
- Хөргөлтийн салбарт хамгийн олон төрлийн бодис ашиглагддаг.

2017 онд импортлох зөвшөөрөл олгосон R32 бодистой агааржуулах төхөөрөмжийн хэмжээг нийт агааржуулах тоног төхөөрөмжийн хэмжээтэй харьцуулсан нь



ТЕХНИКИЙН АЖИЛТНУУДЫН ЧАДАМЖИЙГ БАТАЛГААЖУУЛАХ, ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ НЬ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

- Хөгжиж буй орнуудын хувьд гидрохлортфторт нүүрстөрөгч (ГХФН/НСFC)-ийг үе шаттай бууруулснаар түүнийг орлуулах ДДНЧ/GWP багатай хөргөх бодисын хэрэглээ өсөн нэмэгдэж байна.
- **Шатамхай, хортой буюу эсвэл өндөр даралтад** ажилладаг.
- Урьд нь хэрэглэгддэг байсан хлортфторт нүүрстөрөгчид (ХФН/СFC), ГХФН/НСFC-өөс эдгээр бодис ялгаатай учир техникийн ажилтануудад төдийлөн танил биш
- Ийм төрлийн хөргөх бодистой хөргөлтийн болон агааржуулалтын төхөөрөмжийн **суурилуулалт, үйлчилгээ, засвар, задаргааг** хийхдээ аюулгүй ажиллагааны үүднээс анхааралтай хандах шаардлагатай.
- Тиймээс ДДНЧ/GWP багатай хөргөх бодистой ажилладаг техникчдийг сургах, гэрчилгээ олгоход үндэсний хэмжээнд нэгдсэн тодорхой тогтолцоо шаардлагатай.

ТЕХНИКИЙН АЖИЛТНУУДЫН ЧАДАМЖИЙГ БАТАЛГААЖУУЛАХ, ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ НЬ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

- “Гэрчилгээ” гэдэг нь хувь хүн (эсвэл аж ахуй нэгж) өөрийн эзэмшсэн боловсрол, сургалтын хөтөлбөр, чадамж, хөндлөнгийн хяналт, үнэлгээнд үндэслэн тухайн ажил, үүргийг бүрэн гүйцэд гүйцэтгэх чадвартайг нь илэрхийлсэн албан ёсны баталгааг хэлнэ.
- Гэрчилгээ нь хуулиар зөвшөөрөгдсөн эсвэл мэргэжлийн үүднээс давуу тал олгодог, сайн дураараа шалгуулж авдаг байж болно.

ТЕХНИКИЙН АЖИЛТНУУДЫН ЧАДАМЖИЙГ БАТАЛГААЖУУЛАХ, ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ НЬ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

- Хөргөлт, агааржуулалтын засвар үйлчилгээний хувьд гэрчилгээ гэдэг нь тоног төхөөрөмж, хөргөх бодистой харьцан ажиллаж байгаа ажилтны ур чадвар, хөргөх бодис алдагдахаас сэргийлэх, сайн туршлагыг баталгаажуулах үүднээс чухал ач холбогдолтой.
- Энэ нь бодисын алдагдлаас үүдэх **байгаль орчны болоод хөдөлмөрийн аюулгүй байдалтай** холбоотой асуудал үүсэхээс сэргийлэх зорилготой юм. Жишээлбэл:
- ХФН/СFC, ГХФН/НСFCs –ДДНЧ ихтэй, ОЗБ
- ГФН/НFC –ДДНЧ ихтэй
- НУ/НС –Шатамхай
- Аммиак–Бага зэрэг шатамхай, хортой
- CO₂–Өндөр даралттай, амьсгал боогдуулна, үнэргүй
- ГФО/НFO - Бага зэрэг шатамхай

ТЕХНИКИЙН АЖИЛТНУУДЫН ЧАДАМЖИЙГ БАТАЛГААЖУУЛАХ, ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ НЬ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

- Хөргөх бодистой харьцах ажилтны ур чадвар байгаль орчны (Жнь: озоны давхаргын нимгэрэл, уур амьсгалын өөрчлөлт – ХФН/СFC, ГХФН/НСFC, ГФН/НFC) болон хөдөлмөрийн аюулгүй байдлын (НУ/НС, Аммиак, CO₂, ГФО/НFO) үүднээс чухал ач холбогдолтой.
- Зөвхөн гэрчилгээ бүхий техникчдэд хөргөлт, агааржуулалтын (RAC) системийн суурилуулалт, үйлчилгээ, засвар, задаргаа, хөргөх бодисын юүлэлт, худалдан авалт хийх зэргийг зөвшөөрч, хариуцуулж байхыг зөвлөж байна.

СУРГАЛТ, ҮНЭЛГЭЭ, ГЭРЧИЛГЭЭНИЙ АЧ ХОЛБОГДОЛ

- Гэрчилгээ нь үндэсний мэргэжилтэн бэлтгэх тогтолцооны дагуу хөдөлмөрийн зах зээлийг хянахад чухал бөгөөд зайлшгүй хэрэгсэл.
- Гэрчилгээжүүлэх эрх зүйн бичиг баримтаар дамжуулан хөргөх бодис агаарт алдагдахыг багасгах, эрчим хүчний үр ашигтай хэрэглээг нэмэгдүүлэхэд нөлөөлөх юм.
- **Засвар үйлчилгээний ажилтан**
- Засвар үйлчилгээний ажилтаны (эсвэл гэрээт гүйцэтгэгч) зүгээс өрсөлдөөн ихтэй зах зээлд илүү чанартай ажил гүйцэтгэх чадвартайгаа батлахад гэрчилгээ давуу тал болно.
- **Үйлчлүүлэгч**
- Үйлчлүүлэгчдийн хувьд (энд бөөний худалдаачид, борлуулагчид, эцсийн хэрэглэгч, үйлчлүүлэгчдийг хамруулан ойлгоно), ялангуяа худалдан авах чадвар өндөртэй хэсэг, байгаль орчинд ээлтэй, эрчим хүчинд хэмнэлттэй бүтээгдэхүүн, өндөр чанартай засвар үйлчилгээ шаардаж болно. Сургалт, үнэлгээ, гэрчилгээ нь холбогдох стандартыг (найдвартай байдал, тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа, байгаль орчинд үзүүлэх нөлөө, урьдчилан сэргийлэх засвар үйлчилгээ зэргийг оролцуулан) хангасан засвар, үйлчилгээгээр дамжуулан үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаална. Иймд хөргөлт, агааржуулалт, дулааны шахуурга зэрэг төхөөрөмжтэй харьцдаг ажилтан, компани/үйлдвэрүүдэд гэрчилгээ шаардагдана.
- Тоног төхөөрөмж, засвар үйлчилгээний хувьд үйлчлүүлэгч зохих гэрчилгээгээр баталгаажсан тодорхой түвшний чанарыг шаардаж болно.

ТЕХНИКИЙН АЖИЛТНУУДЫН ЧАДАМЖИЙГ БАТАЛГААЖУУЛАХ, ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ НЬ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

- Хэдийгээр дэвшилтэт технологи, өндөр чанартай төхөөрөмж, сэлбэг худалдан авснаар хөргөх бодисын ялгарал багасч, эрчим хүч хэмнэх боломжтой боловч тоног төхөөрөмжийн
- угсралт,
- суурилуулалт,
- цэнэглэлт, засвар үйлчилгээг зөв сайн хийснээр системийн үйл ажиллагаа сайжирч, бодис шууд болон шууд бусаар (Жишээ нь, эрчим хүчний хэмнэлт хийх) ялгарахыг мэдэгдэхүйцээр бууруулж чадна.
- Хөргөлтийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ нь шууд бусаар хүлэмжийн хийн ялгаралд хэмжиж болохуйц нөлөө үзүүлж чадна.

ТЕХНИКИЙН АЖИЛТНУУДЫН ЧАДАМЖИЙГ БАТАЛГААЖУУЛАХ, ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ НЬ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

- Засвар үйлчилгээний техникчид мөн өөрсдийн давуу байдал, чадварыг харуулахыг хүсдэг ба шатамхай, хортой, өндөр даралтад орлуулах бодисыг хэрэглээнд нэвтрүүлэх ёстой болсон тул хөгжиж буй орнууд том боломжийн хамт томоохон сорилттой тулгараад байна.
- ГХФН/НСFC-ийн хэрэглээг бууруулахдаа засвар үйлчилгээний салбарыг тэргүүн эгнээнд тавьж байгаа хөгжиж буй орнуудын хувьд шаардлагатай үр дүнд хүрэхийн тулд сайн суралцсан, чадварлаг хөргөлтийн болон агааржуулалтын засвар үйлчилгээний ажилтнууд маш их хэрэгтэй байна.

ТЕХНИКИЙН АЖИЛТНУУДЫН ЧАДАМЖИЙГ БАТАЛГААЖУУЛАХ, ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ НЬ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

- Хөргөх бодис агуулсан хөргөлт, агааржуулалтын систем суурилуулах, засвар үйлчилгээ хийх, бодисыг нь юүлэх, задлах зэрэг ажлыг зөвхөн гэрчилгээтэй техникийн ажилтан хийхийг зөвлөдөг ба илүү чухал нь зөвхөн гэрчилгээтэй техникчид хөргөх бодис худалдан авах эрхтэй байвал зохино.
- Албан бус салбарын хөгжил, тэдний цаашид тэлэх боломжийг хязгаарлах ба ийм салбарт нийтлэг байдаг чанаргүй засвар, үйлчилгээнээс сэргийлэхэд хувь нэмэр оруулна.

ОЗБ БОЛОН ОРЛУУЛАХ БОДИСТОЙ ХОЛБООТОЙ ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ

Хөргөлт, агааржуулалтын
засвар үйлчилгээний
техникийн ажилтнуудыг
гэрчилгээжүүлэх
тогтолцоо нэвтрүүлж
хэрэгжүүлэх талаарх
үндэсний оролцогч
талуудын зөвлөлдөх
уулзалт

- Гэрчилгээжүүлэхтэй холбоотой эрх зүйн үндсийг боловсронгуй болгох, цаашдын хэрэгцээ шаардлага
- Гэрчилгээжүүлэх тогтолцоо бүрдүүлэх замын зургийн төсөл

2018.06.08

Улаанбаатар зочид буудал,
Хөх асар танхим
Улаанбаатар хот

А. Сайнбаяр: БОАЖЯ-ны Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
Д. Дуламсүрэн: ОУА-ны ахлах мэргэжилтэн
Ц. Мөнхбат: Байгаль орчны аудитор (МВА)

ТУХАЙН АСУУДЛААР МОНГОЛ УЛСЫН НЭГДЭН ОРСОН КОНВЕНЦУУД



Конвенци/нэмэлт өөрчлөлт	УИХ –аар батлах / нэгдэн орох / хүлээн зөвшөөрөх / баталгаажуулах
Венийн конвенц (1985)	1996 оны 3 сарын 7-нд баталсан
Монреалийн протокол (1987)	1996 оны 3 сарын 7-нд баталсан.
Лондоны нэмэлт өөрчлөлт (1990)	1996 оны 3 сарын 7-нд баталсан
Копенгагены нэмэлт өөрчлөлт (1993)	1996 оны 3 сарын 7-нд баталсан
Монреалийн нэмэлт өөрчлөлт (1997)	2002 оны 3 сарын 28-нд баталсан.
Бээжингийн нэмэлт өөрчлөлт (1999)	2002 оны 6 сарын 24-нд баталсан.
Кигалигийн нэмэлт өөрчлөлт (2016)	Батлахаар хүлээгдэж буй.

Кигалийн нэмэлт өөрчлөлт нь 2050 он гэхэд 70 тэр бум CO₂ экв. тн хүлэмжийн хий агаарт хаягдахаас зайлсхийж, 2015 онд НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцийн (НҮБУАӨСК) ээлжит хуралд оролцогч 195 орон уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, нүүрсхүчлийн хийн ялгарлыг бууруулах, тогтвортой хөгжлийг дэмжих тухай Парисын гэрээг хэрэгжүүлэх хөшүүрэг болно. **ҮҮНД ХӨРГӨЛТ, АГААРЖУУЛАЛТЫН ИНЖЕНЕР, ТЕХНИКЧДИЙН МЭРГЭШЛИЙН УР ЧАДВАР, МЭДЛЭГ, ХАНДЛАГА АСАР ЧУХАЛ ҮҮРЭГ ОРОЦООТОЙ ЮМ.**

Хууль эрх зүйн орчин

- Үндсэн хууль 1992 он
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль 2001 он
- Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль 2006 он
- Гаалийн тухай хууль 2008 он
- Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль 2009 он
- Агаарын тухай хууль 2012 он
- Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоол
- Төрөөс экологийн талаар баримтлах бодлого УИХ-ын 1997 оны 109 дүгээр тогтоол

Бодлогын баримт бичгүүд:

- Озоны үе давхаргыг хамгаалах үндэсний хөтөлбөр Засгийн газрын 1999 оны 129 дүгээр тогтоол
- Озон задалдаг бодисыг импортлох, худалдах, ашиглах зөвшөөрөл олгох журам Засгийн газрын 1999 оны 104 дүгээр тогтоол.
- Монгол Улсад ашиглахыг хориглосон болон хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалт Засгийн газрын 2007 оны 95 дугаар тогтоол / нэмэлт оруулах тухай Засгийн газрын 2012 оны 145 дугаар тогтоолоор 2007 оны 95 дугаар тогтоолын 1, 2 дугаар хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулсан. /93-126 дугаарт 34 төрлийн HCFC бодис орсон/
- Байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол, хаягдлыг багасгах, байгальд аюулгүй техник, тоног төхөөрөмжийн жагсаалт Засгийн газрын 2013 оны 303 дугаар тогтоол.
- Монгол Улсад хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааны кодолсон жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын 2014 оны 378 дугаар тогтоол.



ОЗОН ЗАДАЛДАГ БОДИС БОЛОН ОРЛУУЛАХ БОДИСТОЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ТОГТООМЖУУД



**Хөргөлт,
агааржуулалтын засвар
үйлчилгээний техникийн
ажилтнуудыг
гэрчилгээжүүлэх
хэрэгцээ шаардлага,
хууль эрх зүйн орчин**



Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлаар

ЗГ-ын 1999 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Озон задалдаг бодис болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийг импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөл олгох журам”-ыг шинэчлэх ажил

Шинээр батлагдах журмын төслийн явцын талаар

Журмын төслийн 3 дугаар зүйлд “Зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага” хэсэгт:

Озон задалдаг бодис болон дэлхийн дулааралд нөлөөтэй бусад орлуулах бодис ашиглан хөргөлт, агааржуулалтын засвар, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага нь мэргэшлийн гэрчилгээтэй засварчин, инженер, техникийн ажилтантай байна гэж тусгаж өгсөн.

Цаашид Агаарын тухай хуулийн 25.4 дэх хэсэгт заасан “Озон задалдаг бодис болон бусад орлуулах бодисыг юүлэх, дахин боловсруулах, тоног төхөөрөмжийг дахин цэнэглэх үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрх олгох асуудлыг судлан шийдвэрлэж эрх зүйн орчныг боловсронгуй болгох

Засгийн газрын 2006 оны 137 дугаар тогтоолоор баталсан Байгаль орчны мэргэжлийн байгууллагын эрх олгох журмын мэргэжлийн байгууллагын төрөлд “2.1.7.Озон задалдаг бодис болон бусад орлуулах бодисыг юүлэх, дахин боловсруулах, тоног төхөөрөмжийг дахин цэнэглэх үйл ажиллагаа”-г хамруулах тусгай зөвшөөрөл олгох боломжийг судлан, шийдвэрлэх.

2.2.1 Озон задалдаг бодисыг юүлэх, дахин боловсруулах, тоног төхөөрөмжийг цэнэглэх, суурилуулах, засвар үйлчилгээ хийх үйл ажиллагааг гүйцэтгэх инженер, техникийн ажилтан, мэргэжсэн боловсон хүчин нь тусгай сургалтанд хамрагдсан байх;

3.2.3 Хөргөлтийн мэргэжлийн боловсон хүчнийг давтан сургах, мэргэжлийн зэрэг дэвийг ахиулах үйл ажиллагааг тогтмол явуулах;

Ямар хүн D ангилалын жолооч болдог вэ?

D ангилалын тээврийн хэрэгслийг жолоодох шаардлага, хэрэгцээ гарсан хүн дараах шаардлагыг хангасан тохиолдолд болно.

- 21 насанд хүрсэн байх
- Цусны бүлэг тогтоолгосон байх
- Тээврийн хэрэгслийн В, С, Е ангилалын аль нэг үнэмлэхтэй байх
- “ВС” –ангиллын тээврийн хэрэгсэл нэг жилээс доошгүй хугацаагаар тасралтгүй жолоодсон байх
- Жолоочийн эрүүл мэндийн үзлэгт орж тэнцсэн байх
- D ангилалын 21 хоногийн сургалтын хөтөлбөрийг бүрэн хангаж, Замын Цагдаагийн Газрын мэргэжлийн шалгалтыг автодромын жолоодлогоор өгч тэнцсэн байх
- Дээрх шаардлагыг хангасан тохиолдолд D ангилалыг жолоодох эрхийг D ангилалын жолоодох эрхийн үнэмлэхээр баталгаажуулна



Хөргөлт, агааржуулалтын засвар үйлчилгээний техникийн ажилтнуудыг гэрчилгээжүүлэх асуудал



Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаар бэлтгэх мэргэжлийн чиглэл, индекс (БСШУС-ын 2016.04.18-ны өдрийн А/150 дугаар тушаал)

Ерөнхий ойлголт

- УАМАТ-ын 7-р үндсэн бүлэг Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан
 - 71- барилга түүнтэй холбогдох ажил мэргэжлийн ажилтан
 - 712 Барилгын гүйцэтгэгч болон түүнтэй холбогдох бусад ажил мэргэжлийн ажилтан
 - 7126- Агааржуулалт, агаар сэлгэлтийн механикч

Салбар, дэд салбарын нэр	Мэргэжлийн боловсрол, сургалт эзэмшүүлэх	Мэргэжлийн сургалт	Мэргэжлийн боловсрол	Техникийн боловсрол	Индекс /УАМАТ-09/				
	Сургалтын хэлбэр, элсэгчдэд тавигдах шаардлага	Чадамжид суурилсан сургалтаар Мэргэжүүлэх	Чадамжид суурилсан сургалтаар	Сурь боловсрол бүхий элсэгчид, бүрэн дүнд боловсролын багт	Мэргэжлийн боловсрол бүхий элсэгчид, Бүрэн дүнд боловсрол бүхий элсэгчид				
Суралцах хугацаа	1 жил хүртэл	I-III	III-IV	III-IV	1.5 жил	3 жил	Чадамжийн үүрэгтэй үзэгчид	Мэргэжлийн индекс	
Мэргэжлийн түвшин									
VIII. Барилгын салбар									
Иргэний барилга, байгууламж	Агааржуулалт, агаар сэлгэлтийн системийн усралт, ашиглалтын техникч	7-14 хоног			x	x	CF	3115-51	
	Сантехник, халаалт, агааржуулалтын төхөөрөмжийн техникч	7-14 хоног			x	x	CF	3115-67	
	Халаалт, агааржуулалтын хөргөлтийн тоног төхөөрөмжийн засварчин	1-3 сар	x	x				CF	7126-26
	Хөргөлтийн тоног төхөөрөмжийн засварчин	21-45 хоног	x	x				CF	8211-23
XIII. Аж үйлдвэрийн салбар									
Салбар дундын мэргэжлүүд	Хөргөлт, агааржуулагч тоног төхөөрөмжийн усралт, ашиглалтын техникч				x	x	IM	3115-57	
	Агааржуулалт, агаар сэлгэлтийн тоног төхөөрөмжийн механикч		x	x			IM	7233-19	
	Агааржуулах болон хөргүүрийн тоног төхөөрөмжийн засварчин		x	x			IM	7233-36	

Үндэсний мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоонд хөргөлт, агааржуулалтын засвар үйлчилгээний техникийн ажилтнуудын ажил мэргэжлийг гэрчилгээжүүлж, баталгаажуулах асуудал



1

Одоогийн байдлаар 25 сургагч багшийг чадавхажуулах сургалтыг Олон улсын байгуулгатай хамтран зохион байгуулаад байна.

4

Мэргэжлийн сургалтын байгууллагаа бүртгүүлэх.

2

Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах

5

Чадамжид суурилсан сургалт явуулж хөргөлт, агааржуулалтын засварчдыг чадамжийн гэрчилгээтэй болгох

3

Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах.


Ажил мэргэжлийг гэрчилгээжүүлж, баталгаажуулах асуудалд холбогдох төрийн захиргааны төв байгууллага, ОУА болон бусад байгууллагуудын зүгээс үзүүлэх дэмжлэг

БОАЖЯ, ОУА-аас сургагч багш бэлтгэхэд хичээл заах гадаадын эксперт багшийг зуулчлан сургалтыг зохион байгуулах, хамтран оролцох замаар дэмжлэг үзүүлэх

БОАЖЯ, ОУА-аас Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийн 5.1 дэх хэсэгт Мэргэжлийн боловсрол, сургалтын зорилго нь "олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн мэргэжлийн ур чадвар, боловсрол эзэмшүүлэх" гэж заасны дагуу чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулахад гадаад орны туршлага, олон улсын нийтлэг жишиг, хандлагын талаарх мэдээллээр хангахад дэмжлэг үзүүлэх

Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/53 дугаар тушаалаар батлагдсан "Мэргэжлийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлага, загвар"-ын 3.3 дахь хэсэгт заасан Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх тохиолдолд шинэ мэргэжил нээх хүсэлтийг хугацаа харгалзахгүй хүлээн авах, шийдвэрлэх тал дээр зохих байгууллагууд хамтран ажиллаж дэмжлэг үзүүлэх боломж

Өмнө нь "Мастер чадамж" сургалтын төвийн сургалтад хамрагдсан засварчин, техникч нар өмнөх мэдлэг, ур чадварыг хүлээн зөвшөөрөх үнэлгээ буюу RPL үнэлгээний дагуу шууд ур чадварын үнэлгээ хийлгэн чадамжийн гэрчилгээ авах боломжтой эсэхийг анхаарч дэмжих



Хөргөлт, агааржуулалтын засварчдыг чадамжийн гэрчилгээтэй болгох замын зургийн төсөл

- ХС-ын 2016 оны А/53 тоот тушаалын дагуу
- Сургалтын үйл ажиллагаа эрхлэх загвар
- Сургалт явуулах загвар
- Техникийн боловсрол сургалтын үйл ажиллагаа эрхлэх загвар
- ХНХС, БСШУС-ын сайдын 2016 оны А/216/А/104 дугаар тушаалын дагуу
- Батлагсан сургалтын хөтөлбөр
- Багшлах эрхтэй багш
- Сургалтын техник хэрэгсэл
- Дадлага хийх нөхцөл

- Ажил мэргэжлийн тодорхойлолт
- Мэргэжлийн боловсрол сургалтын стандарт боловсруулах MNS 6541:2015
- Дээрх стандартыг боловсруулах баг бүрдүүлэх
- БСШУС-ын А/150 дугаар тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах

Start Here




ХӨРГӨЛТ, АГААРЖУУЛАЛТЫН ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНИКИЙН АЖИЛТНУУДЫГ ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ, БАТАЛГААЖУУЛАХ ТОГТОЛЦОО НЭВТРҮҮЛСЭН ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Монреалийн протоколыг хэрэгжүүлэхэд туслах хөтөлбөр, OzonAction-ийн илтгэл

ХӨРГӨЛТ, АГААРЖУУЛАЛТЫН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНИКИЙН АЖИЛТНУУДЫГ ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ ТОГТОЛЦОО НЭВТРҮҮЛЖ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААРХ ҮНДЭСНИЙ ОРЛОЦОГ ТАЛУУДЫН ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ

Монреалийн протоколын хөтөлбөрийн ажилтан, Ляззат Раббиоси

Хөргөх бодис шилжих явцад үүсч буй төвөгтэй байдал



РАС техникийн ажилтнуудыг яагаад гэрчилгээжүүлэх хэрэгтэй вэ?

- CFC, HCFC – ДДНЧ өндөртэй, ОЗБ
- HFC – ДДНЧ өндөртэй
- HC - Шатамхай
- Аммиак – Бага зэргийн шатамхай, хортой
- CO₂ – Өндөр даралттай, амьсгал боогдуулна
- HFO - Бага зэргийн шатамхай

Байгаль орчноо хамгаалах

Аюулгүй байдал

HVAC системийн суурилуулалт, ашиглалт, засвар, задаргааг зөв хийж байгаа эсэх мөн ажилтнуудын чадамжийг баталгаажуулж, шалгахад гэрчилгээжүүлэлт хамгийн үр дүнтэй арга юм.

Шинээр гарч буй асуудлууд



Гэрчилгээжүүлэлт гэж юу вэ?



- **Гэрчилгээжүүлэлт** – гэдэг нь хувь хүн болон аж ахуйн нэгж боловсрол, сургалт, хөндлөнгийн хяналт, үнэлгээний үр дүнд тухайн ажил, даалгаврыг гүйцэтгэх чадамжтайг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн баримт юм.
- Гэрчилгээжүүлэлт нь **хуулиар шаарддаг** баримт бичиг эсвэл мэргэжлийн давуу тал олгох **сайн дурын арга хэмжээ** байж болно.
- Хуулиар заавал шаарддаг гэрчилгээжүүлэлтийн схем нь техникийн ажилтнууд болон аж ахуйн нэгжүүдийн хувьд дагаж мөрдөх хүчтэй хөшүүрэг болж өгдгөөрөө давуу талтай.

Гэрчилгээжүүлэлтийн төрлүүд

Хувь хүний

Бүх төрлийн үйл ажиллагаа эсвэл өөр өөр чадамжийн төрлүүдэд тохирсон тусгай хэдэн үйл ажиллагааг гүйцэтгэх чадвартайг илэрхийлнэ. Жнь: Европын Холбооны Фторт хийний журам (EU F-gas regulation): үйлчилгээ болон засвар хариуцсан мэргэжилтэн

Аж ахуйн нэгжийн

Ажилчдыг гэрчилгээжүүлэх буюу худалдааны лиценз байдлаар

Мэргэшил

- Үндэсний боловсролын стандарт
- ОЗБ-той харьцах зөв дадал, зуршлыг үндэсний сургалтын хөтөлбөр, техникийн болон мэргэжлийн боловсролд тусгах



Сургалт

- Диплом
- Мэргэжлийн сургалт (RPL-амьдрах орчин, ажил амьдралаас олсон туршлагад суурилсан)
- Богино хугацааны курс

Гэрчилгээжүүлэлт

- Амьдрах орчин, ажил амьдралаас олсон туршлагыг үнэлэх (Түвшин тогтоох тест)
- Үнэлгээ
- Бүртгэл (Гэрчилгээтэй ажилтнуудын нэгдсэн бүртгэлийн сан)

Тусгай зөвшөөрөл


- Аж ахуйн нэгж
- Техникийн ажилтнууд

Мониторинг ба хэрэгжүүлэлт

- Боломжит арга хэмжээний тоо

Гэрчилгээжүүлэх явц

Байгууллагын бүтэц, зохион байгуулалт



Тавигдах хамгийн бага шаардлагууд

- Хараат бус байдлыг нэмэгдүүлэхийн тулд сургалтаар хангах болон, гэрчилгээжүүлэлтийн байгууллагууд тус тусдаа байх
- Үнэглээний ажилтан, сургагч багш нар өөрсдөө гэрчилгээтэй байх
- Үнэглээний ажилтнууд тухайн салбарт олон жил ажилласан туршлагатай байх
- Үнэглээний ажилтнууд суралцагчдыг чөлөөтэй үнэлэх боломжтой байх
- Олон улсын ISO 17024 гэх мэт стандартад тодорхойлсны дагуу



Жишээ: ЕХ-ны Фторт хийний гэрчилгээжүүлэлт

ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ

A – ШАТАМХАЙ ХӨРГӨХ БОДИСУУД

Европын нийгэмлэгийг сургах хөтөлбөрийн үндсэн дээр Жинхэнэ орлуулах бодис

- Сайн дурын
- Гэрчилгээжүүлэлтийн байгууллага: Centro Studi Galileo
- Аюулгүй байдлын асуудал, арга хэмжээнүүд: EN378-1-2-3-4 EC Directive ATEX 94-ATEX 99
- Дагаж мөрдөх ёстой дадал, зуршил, удирдамж: IOR – GIZ – AREA

B – ГФН/НФС ТӨРЛИЙН ХӨРГӨХ БОДИСУУД

Европын ЕС 517/2014 (ЕС 842/2006) удирдамжийн үндсэн дээр

- Заавал дагаж, мөрдөх (Европын Нийгэмлэг дотор)
- Гэрчилгээжүүлэлтийн байгууллага: CENTRO STUDI GALILEO
- Гэрчилгээжүүлэлтийн байгууллага: CEPAS (Accredia) - Итали
- Европын Нийгэмлэг дотор хүчин төгөлдөр
- Дэлхий даяар хүлээн зөвшөөрсөн

Хууль сахиулах, мониторинг



Онлайн бүртгэлийн системийн жишээ (Итали)

- Баталгаа болгож: онлайнаар бүртгүүлсэн бүх гэрчилгээтэй ажилтан, байгууллагуудын нэр
- Хүн бүхэн энэхүү бүртгэлийг харах боломжтой





Стандарт яагаад чухал вэ?



- Стандарт гэдэг нь бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний тодорхой жигд түвшнийг баталгаажуулсан, мэргэжилтнүүд боловсруулсан албан ёсны баримт, бичиг.
⇒ **Гэрчилгээжүүлэх тогтолцоог нэвтрүүлэх, сайжруулахад суурь, лавлах материал, жишээ болгон ашиглаж болно.**
- Техникийн ажилтан, ААН-үүдийн гэрчилгээжүүлэлтийн асуудлыг хамарсан олон улсын, бүсийн хэд хэдэн стандарт бий:
 - ✓ EN 13313:2010 Хөргөлтийн систем болон дулааны насос - Ажилтны ур чадвар
 - ✓ EN 378:2008 Хөргөлтийн систем болон дулааны насос – Аюулгүй байдал ба байгаль орчны шаардлага
 - ✓ ISO 5149:2014 Хөргөх систем ба дулааны насос – Аюулгүй байдал ба байгаль орчны шаардлага
 - ✓ ISO 817:2014 Хөргөх бодис – Тодорхойлолт ба аюулгүй байдлын ангиллын техникийн асуудал
 - ✓ ISO 17024:2012 Тохирлын үнэлгээ – Гэрчилгээжүүлэлтийг хариуцаж буй байгууллага болон хүмүүст тавих ерөнхий шаардлага

Чиг хандлагын ялгаа



- **Засгийн газрын чиг хандлага:** Байгаль орчны болон аюулгүй байдлын бодлогыг сахиулах, хамгийн сайн дадал, зуршил хэрэглэж буй эсэхийг баталгаажуулж хөргөх бодисын алдагдлаас сэргийлэх. 
- **Хэрэглэгчийг хамгаалах (бөөний худалдаачин, борлуулагч, эцсийн хэрэглэгч):** Хэрэглэгч байгаль орчинд ээлтэй, эрчим хүчинд хэмнэлттэй, өндөр чанартай бүтээгдэхүүн болон АЮУЛГҮЙ засвар, үйлчилгээг хүснэ. Гэрчилгээжүүлэлт нь холбогдох стандартын дагуу үйлчилгээ үзүүлж, тэдний ашиг сонирхлыг хамгаална. 
- **Техникийн ажилтнуудын хувьд ямар үнэ цэнтэй вэ?:** Техникийн ажилтнуудад мөн чадамж, ур чадвараа батлан үзүүлэх “нэмэлт үзүүлэлт” болж чадна. 
- **Хөргөлт, агааржуулалтын холбоо:** Санхүүгийн тогтвортой байдлыг хамгаалах эх үүсвэр, үйл ажиллагааны чухал дэмжлэг болж чадна. 

Давуу тал / нөлөө / ашиг тус



- Сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан техникийн ажилтнууд бэлэн байна гэдэг **зах зээлд шинэ төрлийн технологи нэвтрэхийн урьдчилсан шаардлага** ба үүнд тогтвортой байдалд дэмжлэг болох суурилуулалт, засвар, үйлчилгээ, г.м. бүгд хамаарна.
- **Хөргөлт, агааржуулалтын салбарын хөгжил, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.** Мөн хөргөх бодисын бохирдол, агаар мандалд алдагдах байдлыг бууруулж ГФН/НФС төрлийн бодисын эрэлт, хэрэгцээг бууруулна.
- **Хууль бус салбарыг журамлана.**

Гаргах хүчин чармайлт, үнэ өртөг



- **Бий болгох:** Олон талт сан (MLF) дараах зүйлст дэмжлэг үзүүлэх боломжтой:
 - Дагаж мөрдөх дадал, зуршлын код боловсруулах, Гэрчилгээжүүлэлтийн хөтөлбөр бий болгох
 - Сайн туршлага дээр тулгуурласан сургалтын хөтөлбөр - сургалтын хөтөлбөрийг шинэчлэх
 - Хууль сахиулах, хянах хэрэгслийг оролцуулаад гэрчилгээжүүлэлтийг зохицуулалтын орчин
- ТМБСБ, Хөргөлт, агааржуулалтын холбооны өөрсдөө санхүүжүүлдэг сургалтын хөтөлбөр
- **Ажиллуулах үнэ өртөг:** дараах зүйлсээс хамаарна:
 - Гэрчилгээжүүлэлтийн ард явагдах бичиг цаасны ажил
 - Онлайн бүртгэлийн ажиллагаа
 - Үнэлгээний байгууллагын асуудал
 - Гуравдагч этгээдээр хянуулж, баталгаажуулах яву
- ТМБСБ, Хөргөлт, агааржуулалтын холбооны өөрсдөө санхүүжүүлдэг сургалтын хөтөлбөр

Гэрчилгээжүүлэх тогтолцоог бий болгохдоо анхаарах зүйлс - 1



1. ГФН/НФС-ээс бусад орлуулах бодис, ГФН/НФС хөргөх бодисын бохирдлыг талбарласан **хөргөлтийн техникийн ажилтнуудад зориулсан гарын авлагыг үндэсний хэлээр, шинэчлэн хэвлүүлж байх.** Эсвэл техникийн болон мэргэжлийн боловсролд зөв, аюулгүй ажиллагааны дадал, зуршлыг нэмж оруулах болон болон тэдгээр сургуулийн сургагч нарыг сургах.
2. Гэрчилгээжсэн техникийн ажилтнуудтай, төхөөрөмж суурилуулах, засвар, үйлчилгээ хийх, алдагдал шалгах, төхөөрөмжийг задлах үйл ажиллагааг гүйцэтгэж чадах, шаардлагатай багаж хэрэгсэлтэй гэдгээ баталсан **засвар, үйлчилгээ эрхэлдэг ААН-ийг гэрчилгээжүүлнэ.**
3. ГФН/НФС төрлийн бодисоор дээрх үйл ажиллагааг зөвхөн гэрчилгээтэй техникийн ажилтан, ААН-үүд явуулах ёстой хэмээн **хуульчлах.**
4. **Үндэсний хөргөлт, агааржуулалтын холбоодыг дэмжих,** үндэмний мэргэжилтнүүдийг олон улсын хурал, зөвлөгөөнд оролцуулах, хэрэглэгч, ГФН/НФС төрлийн бодис агуулдаг төхөөрөмж эзэмшигчдэд мэдлэг олгох workshop-ууд зохион байгуулах.

Гэрчилгээжүүлэх тогтолцоог бий болгохдоо анхаарах зүйлс - 2



5. Үндэсний сургалтын хөтөлбөр, гэрчилгээжүүлэх тогтолцоог хэрэгжүүлэх нь маш их нөөц бололцоо, ажил, цаг хугацаа шаардана. Тиймээс **ийм сургалтын хөтөлбөрүүд нь санхүүжилт, зохих сургалтын материал бэлэн болмогц эхлэх хэрэгтэй.**
6. ГФН/НФС төрлийн бодисын хэрэглээ, түүнийг ауулсан төхөөрөмж шинээр суурилуулахыг хориглох цаг үе болон түүнийг орлуулах технологи өргөн хүрээнд нэвтрэх явдал давхцаж магадгүй учир урьтаад нэлээд олон техникийн ажилтныг сургаж, бэлдэх хэрэгтэй. Ийм хоригийг 2024/2028 онд тус бодисын хэрэглээг царцаах үеэр хэрэгжүүлэх төлөвтэй байгаа тул эдгээр сургалтыг аль болох эрт эхлүүлэх хэрэгтэй.
7. Сургалтад онолын хичээл, дадлага ажил хоёуланг нь хамруулах хэрэгтэй. Дадлага ажил нь **юүлэх, дахин боловсруулах төхөөрөмж г.м. сургалтын тоног төхөөрөмж худалдаж авахыг шаардаж болно.**

Боломжууд

- НҮБ-ын БОХ, OzonAction-ийн гар утасны аппликейшн, онлайн сургалт г.м. янз бүрийн төрлийн бүтээгдэхүүн, багаж хэрэгслүүд.
- Олон улсын хэд хэдэн үнэ төлбөргүй, шинэчлэгдсэн сургалтын эх сурвалжийг санал болгож, боловсруулж байна. Жнь. Европын Холбооны REAL Alternative хөтөлбөр



Тавдугаар зүйлийн бус орнуудын жишээ

- АНУ: Сургалт, гэрчилгээжүүлэлтийн шаардлагууд ГФН/НFC төрлийн бодистой харьцдаг техникийн ажилтнуудыг хамаарна.
- Канад: Тоног төхөөрөмж ашиглах, засвар, үйлчилгээ хийхдээ бүх төрлийн ОЗБ, ГФН/НFC бодисын ялгарлыг багасгах хамгийн сайн дадал, зуршлыг нэвтрүүлсэн.
- Австрали: ГХФН/НСFC, ГФН/НFC төрлийн бодистой тусгайлан заасан төхөөрөмжүүдэд засвар, үйлчилгээ хийх тусгай зөвшөөрөл авахад тухайн тоног төхөөрөмжид хамааралтай гэрчилгээтэй байхыг шаарддаг.
- Япон Улсад худалдааны хөргөх, агааржуулах төхөөрөмжид үйлчилгээ хийхээс хаях хүртэл хугацаанд ХФН/СFC, ГХФН/НСFC, ГФН/НFC төрлийн бодисуудыг зөвхөн гэрчилгээтэй этгээд юүлэхийг шаарддаг.
- Европын Холбоо (ЕХ)-ны Фторт хийний тухай журам нь хөргүүртэй том оврын машин, чиргүүл, хөргөлт, агааржуулалт, дулааны насосын суурин төхөөрөмжийг суурилуулах, алдагдлыг шалгах, бодис юүлэх, засвар, үйлчилгээ хийх, задлах ажлуудыг гүйцэтгэж буй **техникийн ажилтнууд, ААН-ийг гэрчилгээтэй байхыг шаарддаг**. Автомашин агааржуулагч төхөөрөмжид засвар, үйлчилгээ хийдэг техникийн ажилтнууд сургалтад хамрагдсан байх шаардлагатай.
- Refrigerant driving license (RDL): Хөргөх бодисын жолоодох эрхийн үнэмлэх – үйлдвэрийн санаачлага

Европын Холбооны Фторт хийний гэрчилгээ

Жинхэнэ орлуулах бодисын гэрчилгээ

- Европын Холбооны Фторт хийний гэрчилгээ (500,000 техникийн ажилтан)
- Өөр, өөр төрлийн хөргөх бодисын модулийг нэмдэг (CO₂, Аммиак, Нүүрсустөрөгч)
- Засвар, үйлчилгээний аюулгүй байдал, үр бүтээмж, найдвартай байдал, бохирдлын асуудалд анхаарал хандуулдаг:
 - Системийн өндөр даралт
 - Шатамхай байдал
 - Хортой байдал



RDL: Үнэлгээний ангилал

- **Тоног төхөөрөмж:** суурин хөргөлт, агааржуулалтын төрлийн төхөөрөмж, дулааны насос, галын хамгаалалт, хөргүүртэй том оврын машин, чиргүүл, MAC
- **Даалгавар:**
 - Суурилуулалт, ашиглалтын явцын үйлчилгээ
 - Засвар
 - Задлах
 - Алдагдал шалгах
 - Юүлэх

RDL CATEGORY A	TASKS			
	Installation	Putting into Operation	Leakage checking	Removing Refrigerant
SKILLS TO ACCESS (T Theoretical – P Practical)				
1. Components of refrigeration systems				
1.1. The refrigerating circuit (RAC and Heat pump installation)	P	P	P	P
1.1.1. Recognize the components and the structure of the system				
1.1.2. Understand the running conditions of the system				
1.1.3. Determine the possible faults				
1.2. Compressor (e.g. comparable)	T	P	P	T
1.2.1. Know the different types of compressors				
1.2.2. Understand the functioning of the compressor				
1.2.3. Understand the possible faults, acid, replacement				
1.3. Lubrication system	T	P	P	T
1.3.1. Know the different lubricants				
1.3.2. Understand the importance of lubricants				
1.3.3. Possible faults, lack of lubrication				
1.4. Condenser	T	P	P	T
1.4.1. Know the different types of condensers				
1.4.2. Understand the functioning of the condenser				
1.4.3. Possible faults, replacement				

Багаж, хэрэгсэл

Equipment and Tools

Equipment and tools of the certified personnel to be supplied by his employer	RC
Manifold	X
Vacuum Gauge or Vacuum Meter	X
Temperature meter	X
Portable leak detector	X
Refrigerant weight Scale	X
Vacuum pump	X
Recovery set	X
Nitrogen pressure regulator	X
Recycling cylinder	X



Figure 5 Vacuum pump



Figure 6 Refrigerant recovery machine



Figure 10 Pressure Manifold



Figure 9 Vacuum Gauge



Figure 8 Scale



Figure 4 Recovery cylinder, how to label it



Figure 7 Leak detector



Figure 11 Temperature Meter

- Тодорхой тооны үнэлгээний ажилтан хариуцах ангид хамгийн ихдээ **20-25** суралцагч
- Үнэлгээний ажилтан(ууд) нь **бие даасан**, сурагцагчдын сургалтад оролцоогүй байх ёстой
- **Олон хариулттай**, 60-90 минутанд гүйцэтгэх, 30-45 асуулттай тест
- Суралцагчид урьдчилан таамаглахаас сэргийлж **төрөл бүрийн асуулттай, ижил тест**
- **Номоо хаасан байх** ба зөвхөн тооны машин, даралт-температур харьцуулагч г.м. тусгай, техникийн багаж, хэрэгсэл ашиглаж болно.
- Гар утас, зургийн аппарат, суралцагчид хоорондоо харилцах эсвэл хуулах асуудал байж **БОЛОХГҮЙ!**
- Тайлбар авах зорилгоор үнэлгээний ажилтантай ярьж **БОЛНО**.
- Онолын мэдлэгийг үнэлэх: **60%-иас дээш зөв хариулж байж тэнцнэ.**
- Лабораторийг дадлага ажлын шалгалт өгөхөд зориулж **бүрэн тоногдсон байх.**
- Дадлагын үнэлгээ: Суралцагч чадамжтай гэдгээ баталж чадвал тэнцүүлнэ.
 - Хөргөлт, агааржуулалтын засвар, үйлчилгээний техникийн ажилтны ажлыг гүйцэтгэхдээ
 - Бага зэргийн эргэлзээтэй эсвэл эргэлзээгүйгээр
 - Хэмжилтийн багаж хэрэгсэл ашиглан температур, даралт, хөргөх бодисын буцлаагүй, шингэн (subcooling), буцлах температураас их температурт буцлаагүй байх (superheating) төлвүүд зэрэг термодинамикийн параметруудийг уншдаг байх
 - Тухайн параметр юу илэрхийлдгийг ойлгодог, хаана алдаа гарсныг олох чадвартай байх
 - Алдагдлын тест хийх
 - Системийг вакуумдах, цэнэглэх, юүлэхдээ хөргөх бодисын ялгарлыг маш бага байлгах
 - Систем; засвар, үйлчилгээ хийсэн тухай тэмдэглэл (logbook)-ийг уншаад ойлгодог байх
 - Холбоосуудыг бодис алдагдуулахгүй сайн гагнах



1. R-32 хөргөх бодис дараах аюулуудтай:

Өндөр зэргийн шатамхай

Бага зэргийн шатамхай

Их хортой

Бага зэргийн хортой

2. Супермаркетын худалдааны давхарт байрлуулсан төхөөрөмжийг хамгийн ихдээ ямар хэмжээний R-290 бодисоор цэнэглэж болох вэ?

Ийм зориулалтаар хэрэглэж болохгүй

150 гр

1.5 кг

Хязгаар байхгүй

3. 20°C хэмд, зогсонги байдалд буй систем

доторх R-744 бодисын даралт хэд вэ?

4.9 бар гр

7.4 бар гр

55 бар гр

72.8 бар гр

4. Ижилхөн хөргөлтийн багтаамж үзүүлэхийн

тулд R-600a бодистой ажиллаж буй компрессор

R-134a бодистой ажиллаж буй компрессортой

харьцангуй ойролцоогоор хэд дахин давшилттай (displacement) ажиллах хэрэгтэй вэ?

Адилхан

2 дахин

7 дахин

Хагас

5. Европын Цэвэр хийний журмын дагуу

(EU517/2014) 300кг R-1234ze хөргөх бодистой системд ямар давтамжтайгаар алдагдал шалгах тест хийж байх ёстой вэ?

Алдагдал шалгах тест хэрэггүй

Жилд нэг удаа

Жилд хоёр удаа

Жилд дөрвөн удаа

6. Аль хөргөх бодисыг литмус цаас (litmus paper) ашиглан илрүүлж болох вэ?

R-32

R-744

R-290

R-717

7. R-1270 хөргөх бодистой ажиллах үед ямар радиусаас дотогш галын эх үүсвэр оруулж болохгүй хэд вэ?

0.3 м

1 м

3 м

10 м

8. Системээс R-744 хөргөх бодисыг гаргахад ихэвчлэн ямар арга ашигладаг вэ?

Шланк ашиглан агаар мандалд шууд гаргаж болно

Өндөр даралттай юүлэх төхөөрөмж ашиглана

Өндөр даралттай бортогонд насосдож хийнэ

Системийг pump down хийнэ.

RDL

Дүгнэлт

- **Бизнесийн загвар:**

- Магадлан итгэмжлэх, мониторингийн ажлуудад хувийн салбар оролцох боломжийг олгох
- Хөргөлт, агааржуулалтын холбоодын оролцоо

- **Хүртээмжтэй байдал:**

- Өөр өөр бүлгүүдэд зориулсан, засвар, үйлчилгээний салбарынханд тохируулсан сургалтын багаж, хэрэгсэл
- Өөр өөр хэл

- **Тогтвортой байдал:**

- Зохицуулах, хууль сахиулах механизм
- Худалдаа, худалдан авалтын практиктай холбогдуулж олон нийтийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх



UN
environment

United Nations
Environment Programme

30
MONTREAL
PROTOCOL
Caring for our life under the sun

Баярлалаа



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
